



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХҮН АМ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН



THE WORLD BANK



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЭГЧ АГЕНТЛАГ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ
ГАЗАР

“И-ЖОБ” ПЛАТФОРМ ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН



2025



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



“И-ЖОБ” ПЛАТФОРМ ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ 2025

Тайлан хянасан:

М. Батгэрэл

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал

Тайлан боловсруулсан:

Н. Жаргалсайхан

М. Ган-Эрдэнэ

Х. Оюунбилэг

Хөдөлмөрийн судалгааны секторын эрхлэгч
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Эрдэм шинжилгээний ажилтан

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Б. Хос-Эрдэнэ

Их өгөгдөл, мэдээллийн технологийн газрын
мэргэжилтэн

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Нарны зам, 55-р
байр 2 давхар 3 тоот Утас: 77111331, 77121286

Веб хуудас: <https://e-mongolia.mn/org/triplsp>

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	7
ӨМНӨХ ҮГ	8
ХУРААНГУЙ	10
БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	14
1.1 Үндэслэл	14
1.2 Зорилго, зорилт	15
1.3 “И-жоб” платформын ерөнхий ойлголт	15
1.4 Судалгааны хамрах хүрээ, түүврийн мэдээлэл	19
1.5 Судалгааны арга зүй, зохион байгуулалт	20
БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ .	22
2.1 Ерөнхий мэдээлэл	22
БҮЛЭГ 3. МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ	24
3.1 Хэрэглэгчийн анкет, ажил зуучлал	24
3.1.1 Хэрэглэгчийн анкет, бүртгэл	25
3.1.2 Ажил зуучлал	26
3.2 ХЭДХ, арга хэмжээ АМЧБОҮ	29
3.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр	30
3.2.2. Ажил мэргэжлийн чиг баримжаа	32
3.3 Тайлан, мэдээ ашиглалт	35
3.4 “И-жоб” платформын сэтгэл ханамж	40
БҮЛЭГ 4. АЖИЛ ОЛГОГЧ, АЖИЛ ХАЙГЧ НАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖ	45
4.1 Ажил олгогч, ажил хайгч нарын ерөнхий шинж чанар	45
4.2 “И-жоб” платформын сэтгэл ханамж	46
БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	53
5.1 Дүгнэлт	54
5.2 Зөвлөмж	54
ХАВСРАЛТ	57

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хэрэглэгчийн бүртгэл, анкет /хувь/	25
Зураг 2. Хэрэглэгчийн бүртгэлд тулгардаг асуудлууд /хувь/	26
Зураг 3. Ажил зуучлал /хувь/	26
Зураг 4. Ажлын байрыг нэрээр хайхад үүсдэг асуудал /хувь/	27
Зураг 5. Ажилд зуучлах үйлчилгээний хамгийн их ажиллагаатай үе шат /хувь/	27
Зураг 6. “И-жоб” платформын ажиллагаа их шаарддаг шалтгаан /хувь/	28
Зураг 7. Ажилд зуучлал амжилтгүй болдог шалтгаан /хувь/	28
Зураг 8. ХЭД төсөл хөтөлбөрийн талаарх мэдээлэл платформд бүрэн байдаг эсэх /хувь/	30
Зураг 9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр /хувь/	31
Зураг 10. ХЭДХ, арга хэмжээний талаарх мэдээллийг шинэчлэх давтамж /хувь/	31
Зураг 11. ХЭДТХ, арга хэмжээнд хамрагдсан иргэдийн бүртгэл мэдээллийг хөтлөхөд үүсдэг асуудал /хувь/	32
Зураг 12. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ /хувь/	33
Зураг 13. Сэтгэл ханамжгүй байх шалтгаан /хувь/	33
Зураг 14. АМЧБОУ-г илүү үр дүнтэй болгохын тулд хийх өөрчлөлт /хувь/	34
Зураг 15. Хэрэглэгчийн бүртгэлийн тайлан, мэдээ гаргах байдал /хувь/	35
Зураг 16. Үүсдэг хүндрэл бэрхшээл /хувь/	35
Зураг 17. Мэдээллийн хадгалагдах байдал /хувь/	36
Зураг 18. Мэдээллийн хадгалагдах байдал хэрэгцээнд нийцдэггүй шалтгаан /хувь/	37
Зураг 19. Платформын процесс хоорондын уялдаа /хувь/	38
Зураг 20. Уялдааг хэрхэн сайжруулах вэ? /хувь/	38
Зураг 21. Орон нутгийн түвшинд дүн шинжилгээ хийх боломж /хувь/	39
Зураг 22. Боломжгүй байдаг шалтгаан /хувь/	39
Зураг 23. Ажлын цагийн хэмнэлт /хувь/	40
Зураг 24. Хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хялбар, оновчтой, шуурхай шийдвэрлэж буй байдал /хувь/	40
Зураг 25. “И-жоб” платформын бүтэц, ажиллагаа, ашиглалт /хувь/	41
Зураг 26. “И-жоб” платформыг ашиглах үед тулгардаг хүндрэл, асуудал /хувь/	42
Зураг 27. “И-жоб” платформд сайжруулах шаардлагатай зүйлс /хувь/ ..	43
Зураг 28. Эдийн засгийн хэмнэлт /хувь/	44
Зураг 29. Ямар зорилгоор бүртгүүлсэн /хувь/	46
Зураг 30. Платформыг хэрэглэхэд хялбар байдал /хувь/	46
Зураг 31. Платформын өнгө, дүрслэл, дизайн /хувь/	47
Зураг 32. Платформын талаарх мэдээллийг хэнээс авсан бэ? /хувь/	48

Зураг 33. Платформд бүртгүүлэх алхам хэр ойлгомжтой байсан бэ? /хувь/	48
Зураг 34. Ажлын зар хангалттай, олон төрөл байсан эсэх /хувь/	49
Зураг 35. Ажилд зуучлал цахим хэлбэрт шилжсэний давуу тал /хувь/ ...	49
Зураг 36. Ажил хайгч болон ажлын байрны мэдээлэл таны шаардлагад хэр нийцдэг эсэх /хувь/	50
Зураг 37. Үүссэн хүндрэл бэрхшээл /хувь/	50
Зураг 38. Платформын юуг сайжруулах шаардлагатай вэ? /хувь/	51

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ерөнхий мэдээлэл /хувь/	22
Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн ерөнхий шинж чанар	24
Хүснэгт 3. Мэргэжилтний сэтгэл ханамж	44
Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан ажил олгогч, ажил хайгч нарын ерөнхий шинж чанар /хувь/	45
Хүснэгт 5. Бусдад санал болгох уу?	52
Хүснэгт 6. Сэтгэл ханамж	53

ХАВСРАЛТ ХҮСНЭГТ

Хавсралт хүснэгт 1. Газар/хэлтсийн дарга хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хялбар, оновчтой, шуурхай шийдвэрлэж буй байдал /хувь/	57
Хавсралт хүснэгт 2. Мэргэжилтэн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хялбар, оновчтой, шуурхай шийдвэрлэж буй байдал /хувь/	57
Хавсралт хүснэгт 3. Газар/хэлтсийн дарга “И-жоб” платформын бүтэц, ажиллагаа, ашиглалт /хувь/	58
Хавсралт хүснэгт 4. Мэргэжилтэн “И-жоб” платформын бүтэц, ажиллагаа, ашиглалт /хувь/	59
Хавсралт хүснэгт 5. Газар/хэлтсийн дарга “И-жоб” платформыг ашиглах үед тулгардаг хүндрэл, асуудал /хувь/	60
Хавсралт хүснэгт 6. Мэргэжилтэн “И-жоб” платформыг ашиглах үед тулгардаг хүндрэл, асуудал /хувь/	60
Хавсралт хүснэгт 7. Газар/хэлтсийн дарга “И-жоб” платформд сайжруулах шаардлагатай зүйлс /хувь/	61
Хавсралт хүснэгт 8. Мэргэжилтэн “И-жоб” платформд сайжруулах шаардлагатай зүйлс /хувь/	62

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЭЗҮАС	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АМЧБОҮ	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ
АЗҮ	Ажилд зуучлах үйлчилгээ
ДБ	Дэлхийн банк
ЗГ	Засгийн газар
СЯ	Сангийн яам
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХАХНХССХ	Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХ	Хөдөлмөрийн хэлтэс
ХЭД	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХЭОНЗ	Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн зөвлөл

ӨМНӨХ ҮГ

Манай Улс урт хугацааны хөгжлийн бодлогодоо (Алсын хараа-2050) “хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх” зорилгыг дэвшүүлсэн. Иймд хөдөлмөрийн зах зээл дэх цахим шилжилтийн хүрээнд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, инновацад суурилсан шийдлүүд улам бүр чухал ач холбогдолтой болж байна.

Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааг дэмжих, өөрөөр хэлбэл ажил хайгч болон ажил олгогчдыг холбох, цахим зуучлалын үйлчилгээний үр ашгийг нэмэгдүүлэх төрийн үйлчилгээг иргэдэд хурдан, хялбар, хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банкны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “И-жоб” платформыг хөгжүүлж, 2023 онд улсын хэмжээнд нэвтрүүлсэн.

Цахим үйлчилгээг 2003 онд зөвхөн 33 оронд санал болгодог байсан бол өдгөө энэ тоо тав дахин нэмэгджээ. Манай орны хувьд анх цахим засаглалыг төрийн үйлчилгээг хурдан шуурхай хүргэх зорилгоор цахим үйлчилгээг нэвтрүүлж эхэлж байсан бол өдгөө цахим засаглалын талаарх бодлого, үйл ажиллагааны чиглэлийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх шаардлага нэгэнт үүссэн байна. Тухайлбал “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д “Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр мэдээллийн аюулгүй байдлын, цахим гарын үсгийн, мэдээллийн сангийн, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт оруулна” хэмээн заасан. Мөн төрийн бүх үйлчилгээг цахимд шилжүүлэх, нээлттэй мэдээллийн өгөгдлийн хэрэглээг иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байлгах зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Энэхүү судалгаа нь “И-жоб” платформын анхны хэрэглэгчдийн сэтгэл ханамж, туршлага, тулгамдаж буй асуудал болон сайжруулах боломжийг бодит баримтад үндэслэн тодорхойлох зорилготой. Судалгааны үр дүн нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч байгууллагуудад платформын хэрэгжилт, хөгжүүлэлтийн дараагийн үе шатанд тулгуур болох суурь мэдээлэл, бодит үнэлгээг өгөх ач холбогдолтой.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлал, судалгаатай холбоотой асуудлаар санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ



М.БАТГЭРЭЛ

ХУРААНГУЙ

Бид хэрэглэгчийн сэтгэл ханамжийг “И-жоб” платформын бүтэц үйл ажиллагаанд өгсөн “Ерөнхий үнэлгээ”, “Бусдад санал болгох эсэх” болон “Мэргэжилтний сэтгэл ханамж” гэсэн гурван үзүүлэлтээр хэмжлээ. Өгөгдөл нь гурван бүлэг хэрэглэгч буюу 209 ажил хайгч, 114 ажил олгогч, 162 мэргэжилтний мэдээллээс бүрдэнэ.


Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нас, хүйс, боловсрол, туршлага зэрэг нийгэм эдийн засгийн хүчин зүйлс, бүртгүүлсэн огноо, төхөөрөмж, хэзээ хамгийн сүүлд ашигласан зэрэг хэрэглээтэй холбоотой хүчин зүйлсээс хамааруулан шинжилсэн.

Насны бүлгийн хувьд авч үзвэл мэргэжилтнүүдийн 35-44 насныхан хамгийн өндөр буюу 48.8% харин ажил олгогчдын хувьд ч мөн насны иргэд 42.1% байна. Ажил хайгч иргэдийн хувьд залуучууд буюу 25-34 насныхан 45.9%-ийг бүрдүүлж байна. Ажил хайж буй иргэдийн 2 хүн тутмын 1 нь залуу насныхан байгаа нь залуучууд хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх эрмэлзэлтэй байгааг илтгэнэ. Боловсролын түвшний хувьд мэргэжилтнүүдийн 75.9% нь, ажил олгогчдын 74.5% нь бакалаврын зэрэгтэй байна. Харин ажил хайгчдын 51.7% нь бакалавр, 31.1% нь бүрэн дунд боловсролтой иргэд байна. Үүнээс харахад “И-жоб” платформ хэрэглэгчдийн боловсролын түвшин өндөр байгааг харуулж байна.

Ажилд зуучлал, ажил мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн “И-жоб” платформ ашиглалтын байдал, үр нөлөө доорх байдлаар үнэлэгдсэн.

Судалгаанд оролцогчдын 50.0% нь “Ажилд зуучлах үйл явцыг системээр дамжуулж хянах, мэдээлэх боломж”-ийг тодорхойлох үзүүлэлтийг дунд зэрэг, дөрөвний гурав нь “Хадгалагдсан ажлын байрны нэр, ангилал ашиглахад тохиромжтой байдал” гэдэгт дунд зэрэг болон дундаас доош үнэлгээ өгсөн нь уг саналыг нухацтай авч үзэх шаардлагатайг харуулж байна.

Ажил зуучлал /хувь/



Судалгааны дүнд системийн хэрэглээ, бүртгэл, анкет бөглөх, ажлын байрны мэдээлэл болон зуучлалын үйл явц дунд түвшинд байгаагаас гадна хэрэглэгчдийн тодорхой хэсэг бүртгэл болон мэдээлэл хайхад хүндрэлтэй байгааг илэрхийлсэн.

Ажлын байрыг нэрээр хайхад үүсдэг асуудал /хувь/



Цахим бүртгэлд мэргэжилтнээр дамжих хандлага давамгайл байгаа нь хэрэглэгчийн цахим ур чадвар болон системийн ойлгомжтой байдлыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Мөн системийн мэдээлэл солилцоо, хадгалалт, ангиллын зөрүү, хайлтын үр дүнгийн бүрэн бус байдал нь мэдээллийн хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.


“И-жоб” платформын ажиллагаа их шаарддаг шалтгаан /хувь/



Судалгаанд оролцогчдын 57.1% нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн мэдээлэл бүрэн байрласан гэж үзсэн бол 42.9% нь дутуу, хүртээмж муутай гэж дүгнэсэн нь мэдээллийн ил тод, нэгдсэн байдлыг сайжруулах хэрэгтэйг илтгэнэ.

Хөтөлбөр арга хэмжээнд хамрагдсан иргэдийн бүртгэл мэдээллийг хөтлөхөд гарч буй асуудлын хүрээнд “Систем дэх мэдээллийг дахин шивэх” болон “Иргэний мэдээлэл дутуу байх” асуудал нь хамгийн их тохиолддог байна. Иргэдийн бүртгэл, мэдээлэлтэй холбоотой хамгийн том хүндрэл нь мэдээллийн давхардал болон дутуу байдал, үүнээс үүдсэн мэдээллийг дахин шивэх асуудал үүсдэг байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр /хувь/



“И-жоб” платформд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний үйлчилгээ нэвтэрснээр хэрэглэгчдэд “ХЭДХ, арга хэмжээний мэдээлэл хэрэгцээтэй, хүртээмжтэй байдал”-ыг онооны өсөх эрэмбийн үнэлгээгээр 1-5-ын хооронд үнэлүүлэхэд 17.9% нь 1 буюу “Маш муу” гэсэн хариултыг сонгосон байгаа бол 5 буюу “Маш сайн” гэж үнэлээгүй байгаа нь энэ талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх байдлыг сайжруулах нэн шаардлагатайг харуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг шинэчлэх давтамжийг мэргэжилтнүүдээс 32.1% нь сар тутам, 28.6% нь 7 хоног тутам шинэчилдэг гэсэн.

Судалгаанд хамрагдсан хоёр бүлгийн /газар, хэлтсийн удирдлагын 53.6%, мэргэжилтнүүдийн 50.0%/ дийлэнх нь мэдээ гаргах явцын үйл ажиллагааг “Дунд зэрэг” гэж үнэлсэн байна. Харин “Хүндрэлтэй” гэж үзсэн удирдлага 21.4%-ийг, мэргэжилтнүүд 22.4%-ийг бүрдүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр /хувь/



“И-жоб” платформын тайлан, мэдээг боловсруулахад тулгамддаг нийтлэг хүндрэл нь Нэгдүгээрт, газар/хэлтсийн удирдлагын 33.3%, мэргэжилтнүүдийн 25.6% нь платформд хадгалагдсан мэдээлэл зөрүүтэй татагддаг гэж үзсэн нь хамгийн түгээмэл тулгардаг асуудал Хоёрдугаарт, удирдлагын 20.0% нь, мэргэжилтнүүдийн 28.7% нь хадгалсан мэдээллийг тайланд ашиглах боломжгүй гэж үзсэн.

Оролцогчид “И-жоб” платформыг ашиглах үед тулгардаг хүндрэлтэй асуудлуудыг 1-5 хооронд үнэлсэн дүнгээр “Системд хандах эрх сэргээхэд хүндрэлтэй байх” гэсэн үзүүлэлт дээр “Хүндрэлтэй” 22.8%, “Маш хүндрэлтэй” 5.6% байгаа бол “Оруулсан мэдээлэл алга болох, устгах, харагдахгүй байх” үзүүлэлт дээр “Хүндрэлтэй” 19.8%, “Маш хүндрэлтэй” 5.6% тус тус өндөр хувийг эзэлж байна.

Ажил хайгч, ажил олгогч болон мэргэжилтнүүд бүгд “И-жоб” платформын бүтэц үйл ажиллагаанд ерөнхий үнэлгээ өгсөн. Ерөнхий үнэлгээг хамааран хувьсагч болгож нийт түүвэр дээр үнэлэхэд ажил хайгч болон ажил олгогчийн өмнөх коэффициент мэргэжилтнүүдийнхээс өндөр бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой байв. Гэвч мэргэжилтэн нь ажил үүргийн хувьд өдөр тутамд хэрэглэдэг ч ажил олгогч, ажил хайгч нь хэрэгцээт үед ашиглаж байгаа давтамжийг харгалзан үзэх хэрэгтэй гэж харж байна.

Цаашид системийн хэрэглэгчийн интерфэйсийг хялбарчилж, мэдээллийн чанар, стандарт, болон хүртээмжийг сайжруулах цахим бүртгэл, чатбот, олон төрлийн зөвлөгөө мэдээллийн сувгийг хөгжүүлэх замаар “И-жоб” платформын үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Үндэслэл

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ) нь “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” (ОБҮДХЭТ)-ийг Дэлхийн банкны Олон Улсын Хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө болон техникийн дэмжлэгтэйгээр ажил хайгч болон бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, богино хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зорилготой 2020-2025 онд хэрэгжүүлсэн. Төсөл нь үндсэн 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

1. Одоогийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тогтолцоог цогц байдлаар шинэчлэн ажил хайгч болон ажил олгогч нарт “үйлчлүүлэгч-төвтэй” үйлчилгээг хувийн зуучлалын байгууллагуудтай хамтран хүртээмжтэй хүргэх;
2. Төслийн хүрээнд сонгосон хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийн дизайн, хамаарал ба эрэлтэд нийцсэн байдлыг бэхжүүлэх;
3. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, дүн шинжилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
4. Бизнес эрхлэгчид болон ажиллагчдад цар тахлын үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зохих шалгуур хангасан ажиллагчид болон ажил олгогчдод богино хугацааны тэтгэмж олгох бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 3-ын хүрээнд төслийн үр шим хүртэгчид болон хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийхээр төлөвлөсөн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн¹ хүрээнд “И-жоб” платформд суурилсан Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн системийг шинэчлэн хөгжүүлэхэд техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, “И-жоб” онлайн портал, мобайл аппликейшныг шинээр нэвтрүүлсэн. Тус порталыг үндэсний хэмжээнд бодлого боловсруулагчид, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн болон нийгмийн ажилтнууд ашиглаж байна. Цахим ажил зуучлал нь ажил хайгч иргэд, ажил олгогчид зайнаас цахим ажил зуучлалын порталд хандах, үйлчилгээ авах хүсэлт гаргах боломжтой шинэлэг үйлчилгээ юм.

1.2 Зорилго, зорилт

Судалгааны зорилго нь онлайн “И-жоб” платформ хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг үнэлж, хөтөлбөр, үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон цаашид хэрэгжүүлэхэд анхаарах санал, зөвлөмж боловсруулах, ажлыг гүйцэтгэх.

Судалгааны үр дүнгээр дараах үзүүлэлтүүдийг тодорхойлно:

- “И-жоб” онлайн портал хэрэглэгчдийн сэтгэл ханамж, порталын хэвийн хангалттай ажиллагаа, үр дүнг тодорхойлох;
- Цахим ажил зуучлалын “И-жоб” порталыг ашигласан хэрэглэгчдийн туршлага, сэтгэл ханамжийн түвшнийг үнэлэх, ажил хайгчдад онлайн үйлчилгээ үзүүлэх давуу болон сул тал, сайжруулах чиглэлүүдийг тодорхойлох;
- Яам, агентлаг, орон нутгийн газар/хэлтсийн хэрэглэгчээс онлайн санал асуулга авч хэрэглэхэд ямар давуу болон сул тал гарч байгааг тодруулах, сайжруулах чиглэлүүдийг тодорхой болгох.

1.3 “И-жоб” платформын ерөнхий ойлголт

Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт болон техникийн тусламжтайгаар хэрэгжүүлж буй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд “И-жоб” платформын дизайн боловсруулах, хөгжүүлж, нэвтрүүлэх болон ашиглалт хариуцах ажлыг “Ай Ти Зон” ХХК нь дараах алсын хараа, зорилго, зорилтуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Алсын хараа: Хэрэглэгчдэд ойр, амьд, технологийн оновчтой, шинэлэг шийдлүүдийг агуулсан, эрх тэгш оролцоог хангасан “И-жоб” платформын тусламжтайгаар ажил хайгч, бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжууд илүү хүртээмжтэй болж, төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ илүү үр өгөөжтэй, үйлчлүүлэгч төвтэй болсон байх.

Эрхэм Зорилго: ГБНХЯ-аас хэрэгжүүлдэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн бизнесийн үйл ажиллагааг цахимжуулан, ажил зуучлалын оновчтой, үр дүнтэй систем бүхий нэгдсэн, динамик “И-жоб” платформыг хөгжүүлэн, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг чанартай, хүртээмжтэй болгон төрийн үйлчилгээг цахимжуулах Цахим Үндэстэн хөтөлбөрт хувь нэмэр оруулах.

Гол Зорилтууд:

1. Чадамж дээр суурилсан ажил зуучлалын шийдэл бүхий “И-жоб” платформыг хөгжүүлэх;
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн динамик модуль хөгжүүлэх;
3. Бүх түвшний оролцогчдын тэгш эрх бүхий оролцоог хангасан хүртээмжтэй “И-жоб” платформыг хөгжүүлэх;
4. Хөдөлмөрийн зах зээлийн тоо баримт, статистик, тайлан мэдээллийн цар хүрээ, хүртээмж, чанарыг сайжруулах системийг хөгжүүлэх.

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан “И-жоб” платформ нь Монгол Улсын хэмжээнд ажил хайгч, ажил олгогчдыг холбох ажил зуучлалын онлайн портал, гар утасны аппликейшнаас гадна Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлэгч агентлаг болох Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хэрэгжүүлдэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэх мэргэжилтнүүдийн нэвтэрч ажиллах дэд системүүдийг агуулсан томоохон хэмжээний цогц платформ юм.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ болох хөдөлмөрийн зах зээлд оролцогчдыг нэгдсэн бүртгэл мэдээллийн үйлчилгээнд хамруулах, ажилд зуучлах үйлчилгээ болон ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ, мөн ХЭД төсөл хөтөлбөрүүдтэй холбоотой үйл ажиллагааг “И-жоб” платформын мэргэжилтнүүдэд зориулсан дэд систем болох Back Office гэсэн нэгдсэн нэг системээр дамжуулан явуулах боломжтой болсон. Мэргэжилтнүүдийн цаг хугацаа ихээр шаарддаг өдөр тутмын үйл ажиллагаа, чиг үүргүүдийг автоматжуулан хялбарчилснаар хэмнэгдсэн цагаа ажил олоход хүндрэлтэй, зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулахад зарцуулах боломжтой болох юм.

Back-Office системийн онцлог

- Төрийн байгууллагуудын сервисүүдтэй холбогдсон
 - “ХУР”, “ДАН” зэрэг төрийн мэдээллийн бусад системтэй холбогдсоноор мэдээллийн үнэн бодит байдлыг магадлан, мэдээллийн давхардал үүсэхээс сэргийлэн, иргэн, аж ахуй нэгжийн мэдээллийг бүртгэх гар ажиллагааг хөнгөвчилнө;
 - Ажил хайгч, ажил олгогч нарын онлайн порталаар дамжуулан оруулсан мэдээлэл нь хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системтэй шууд холбогдон жагсаалтад нэмэгдэх тул мэргэжилтэн харах боломжтой.

- Тохирлын алгоритм дээр суурилсан, ажил хайгч ажил олгогчийг холбох автомат ажилд зуучлалын үйлчилгээ
 - Ажил хайгч, ажлын байрны өгөгдөл дээр суурилан бүртгэлтэй ажил хайгч иргэнд тохирох ажлын байр, ажил олгогчдод тохирох ажил хайгчийг санал болгох замаар ажилд зуучлалыг автоматжуулж байгаагаараа онцлог бөгөөд орчин үеийн технологи дээр суурилсан энэхүү автомат санал болголт нь бодит цагийн горимд их хэмжээний өгөгдлийг боловсруулахдаа дата аналитик, хиймэл оюуны machine learning буюу машин өөрөө суралцах алгоритмуудыг ашиглан хамгийн тохиромжит ажлын байр болон ажил хайгчийг таамаглахаар зохиогдсон;
 - Ажил хайгч болон ажлын байрны өгөгдөл дэх байршил, хүн ам зүйн мэдээлэл, ажлын түүх, ангилал код, түлхүүр үгс гэх мэт 20 гаруй шалгуур үзүүлэлт дээр үндэслэн тохирлын хувийг гаргаж өгснөөр мэргэжилтний ажил зуучлалын чиг үүргийг хялбарчилж, зуучлалыг илүү үр дүнтэй болгоно.
- Найдвартай, хурдтай ажиллагаа
 - Ачаалал тэнцвэржүүлж ажиллах шийдлүүдийг дэд бүтцийн түвшинд болон application server буюу аппликейшн сервер, data-base server буюу өгөгдлийн баазын сервер түвшинд хийж өгснөөр, мөн тайлангийн хэсэг дээр data warehouse буюу өгөгдлийн уурхайн зохион байгуулалтыг хийж өгснөөр системийн ачаалал даах болон хурдтай ажиллах боломжийг хангаж өгч байгаа.
- Бусад онцлогууд
 - Ажил хайгчдад үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд аль аль нь өөрийн эрхийн хүрээнд нэвтрэх боломжтой;
 - Дэд системүүд хоорондоо мэдээлэл солилцох боломжтой бөгөөд ингэснээр мэдээллийн давхардал үүсэхгүйгээр адилхан байдаг бүртгэлийг нэг газраа бүртгэж, бусад ашиглагдах хэсэгт мэдээллийг дуудаж, холбогдох боломжтой.

Back-Office системийн бүрэлдэхүүн хэсгүүд:

- Төсөл хөтөлбөр;
- АМЧБОУ;
- Ажил зуучлал;
- Тайлан;
- Хэрэглэгчийн удирдлага тохиргоо;

- Ангилал код удирдлага тохиргоо үндсэн зургаан модулиас бүрдэх бөгөөд модуль тус бүр 2-оос 4 хэсэгтэй ба хэсэг тус бүр дотроо дэд хэсгүүдийг агуулна.

АЖИЛ ОЛГОГЧ, АЖИЛ ХАЙГЧ

Ажил хайгч

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан “И-жоб” платформ нь Монгол улсын хэмжээнд ажил хайгч, ажил олгогчдыг тохирох нийцлээр нь холбох алгоритм дээр үндэслэсэн ажил зуучлал болон АМЧБОУ-г багтаасан Нийтлэг үйлчилгээ, нийт 7 хөтөлбөр 28 арга хэмжээнээс бүрдсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, ажил хайгч болон ажил олгогчдод зориулагдсан онлайн портал, гар утасны аппликейшнаас гадна ХХҮГ/ХХҮХ болон хөдөлмөрийн хувийн биржийн мэргэжилтнүүд нэвтэрч ажиллах back office зэрэг дэд системүүдийг агуулсан томоохон хэмжээний цогц платформ юм.

Ажил хайгч “И-жоб” онлайн порталыг ашигласнаар дараах үйлчилгээг авах боломжтой:

- Ажил олгогчтой шууд онлайнаар холбогдох;
- Профайлаа үүсгэн, анкетаа хэд хэдэн хувилбараар үүсгэх;
- Зөвхөн танд тохирсон ажлын байрыг автоматаар санал болгох систем;
- Ажилд горилох үйл явцын төлөвүүдээ Канбан самбараас хянан удирдах;
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө үйлчилгээ;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэл авч хамрагдах.

Харин ажил хайгч нь “И-жоб” mobile аппликейшн ашигласнаар дараах үйлчилгээг авах боломжтой:

- Өөрийн анкетаа хялбараар үүсгэх;
- Ажил олгогчийн мэдээлэл болон зарласан ажлын байртай танилцаж анкетаа илгээх;
- Автоматаар санал болгох системийн тусламжтайгаар хайж буй ажлын байрандаа ажилд орох;
- Ажилд орох үйл явцын төлөвүүдээ канбан самбараар хянан удирдах;
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт илгээсэн хүсэлтийн төлөвөө хянах.

Ажил олгогч

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан “И-жоб” платформ нь Монгол улсын хэмжээнд ажил хайгч, ажил олгогчдыг холбох ажил зуучлалын Онлайн портал, гар утасны аппликейшнаас гадна Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлэгч агентлаг болох Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хэрэгжүүлдэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэх мэргэжилтнүүдийн нэвтэрч ажиллах дэд системүүдийг агуулсан томоохон хэмжээний цогц платформ юм.

Ажил олгогч “И-жоб” онлайн порталыг ашигласнаар дараах үйлчилгээг авах боломжтой:

- Ажил хайгчтай шууд онлайнаар холбогдон анкет үзэх хүсэлт илгээх;
- Ажлын байрны мэдээллээ үнэ төлбөргүй нээлттэй олон нийтэд зарлах;
- Автоматаар санал болгох системийн тусламжтайгаар танай ажлын байранд тохирох мэдлэг, ур чадвар, туршлагатай танд тохирсон ажил хайгчийг олж авах;
- Ажил олгогчдод чиглэсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн талаарх мэдээлэл авах, хамрагдах;
- Анкет ирүүлсэн ажил хайгчдыг ажлын ярилцлагад урих, нөөцөд авах зэрэг сонгон шалгаруулалтын үйл явцаа хянах, удирдах;
- Хүний нөөцийн мэргэжилтнүүд нөөцөд авсан ажил хайгчдын анкетын санг бүрдүүлэх.

1.4 Судалгааны хамрах хүрээ, түүврийн мэдээлэл

“И-жоб”-д сэтгэл ханамжийг үнэлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нарын төлөөлөл болох мэргэжилтэн газрын дарга, ажил хайгч, ажил олгогч гэсэн 3 бүлгийн 500-аас доошгүй “И-жоб” платформын хэрэглэгчдийг хамруулна.² Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газраас платформын хэрэглэгч болох ажил олгогч, ажил хайгч нарын мэдээллийг жагсаалтаар авч R studio программ дээр санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгаанд хамруулсан. Харин бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нарын төлөөлөл нийслэл аймаг, дүүрэг, хороодын хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтсийн мэргэжилтэн нарын хувьд 21 аймаг 9 дүүргээс хамруулсан бөгөөд аймгийн болон дүүргийн төвийн 3 мэргэжилтэн, сум хороодын 3-н мэргэжилтэн хамруулсан.

²Дэлхийн банкны ажлын даалгавар

1.5 Судалгааны арга зүй, зохион байгуулалт

“И-жоб”-д сэтгэл ханамжийг үнэлэхдээ хэрэглэгч ба үр шим хүртэгч гэсэн 2 үндсэн бүлэгт хуваасан. Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газраас “И-жоб” платформын үр шим хүртэгч болох ажил олгогч, ажил хайгч нарын мэдээллийг жагсаалтаар авч R studio программ дээр санамсаргүй түүврийн аргаар сонгон асуулга, ярилцлагын аргаар утсаар судалгааг зохион байгуулсан. Харин “И-жоб” платформын хэрэглэгч болох бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нарын төлөөллөөс газар дээр нь очиж асуулгаар судалгаа авсан.

1. Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд

- Судалгааны арга зүйг тодорхойлох, ажлын төлөвлөгөө хуваарь батлуулах;
- Судалгааны асуулга, гарын авлага шинэчлэн, боловсруулж, турших;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн мэргэжилтнүүдтэй хамтарсан мэдээлэл цуглуулах багийг бүрдүүлэх;
- Туршилтын үр дүнг тусган асуулгын хуудсыг эцэслэж бэлэн болгох.

2. Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд

- Цахим ажил зуучлалын портал хэрэглэгчдээс батлагдсан асуулга, ганцаарчилсан ярилцлагын аргаар сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэл цуглуулах;
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн мэргэжилтнүүдтэй хамтран судалгааны баг ганцаарчилсан ярилцлага асуулгын аргаар үр шим хүртэгчдээс сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэл цуглуулах;
- Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн мэдээлэл цуглуулалт гүйцэтгэж байгаа мэдээлэл цуглуулах багт хяналт тавьж ажиллах;
- Цуглуулсан дата мэдээллийг үр дүнгийн тайлан боловсруулахад бэлэн болгох үүднээс мэдээллийг нэгтгэх.

3. Боловсруулалт хийх ажлын хүрээнд

Судалгааны мэдээллийг зориулалтын программд шивж оруулах, үр дүнг боловсруулж, шинжилгээ хийхэд STATA, R программ хангамжийг ашиглана. Мэдээлэл цуглуулж буй аргаас хамаарч мэдээллийг нэгтгэхэд өөр төрлийн программ хангамж ашиглаж болно.

Судалгааны хүрээнд дараах ажлууд хийж гүйцэтгэсэн байна.

- Мэдээллийн санд хяналтын ажлыг хийх;
- Мэдээллийн тойм бэлдэх /outline/;
- Үр дүнгийн хүснэгт, график бэлтгэх;
- Судалгааны үр дүнгийн тайлан боловсруулах.

4. Үр дүнг тайлагнах

Судалгааны үр дүн нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч байгууллагуудад платформын хэрэгжилт, хөгжүүлэлтийн дараагийн үе шатанд тулгуур болох суурь мэдээлэл, бодит үнэлгээг өгөх ач холбогдолтой тул захиалагч болон мэдээллийн хэрэгчдэд үр дүнг нэгдсэн байдлаар танилцуулах. Судалгааны хүрээнд дараах ажлууд хийж гүйцэтгэсэн байна.

- Судалгааны үр дүнгийн тайланг урьдчилсан байдлаар хэлэлцүүлэх;
- Үр дүнгээр танилцуулга, тархаах материал бэлтгэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, хэрэглэгчдэд танилцуулах, тархаах арга хэмжээг зохион байгуулах;
- Үр дүнгийн тайланг хүрээлэнгийн судалгааны цахим мэдээллийн санд байршуулах.

БҮЛЭГ 2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 Ерөнхий мэдээлэл

Судалгаанд цахим ажил зуучлалын “И-жоб” платформ хэрэглэгч 485 иргэн хамрагдсан. Үүнээс бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч болон нийслэл аймаг, дүүрэг, хороодын хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтсийн мэргэжилтэн нарын төлөөл болох 162 мэргэжилтэн хамрагдсан. Улсын хэмжээнд дээрх чиг үүргийн хүрээнд нийт 1,395 мэргэжилтэн албан хаагчид байдаг. ХХҮЕГ-ын “И-жоб” платформд бүртгэлтэй нийт 28,427 ажил олгогч иргэн, ААН байгаагаас 114, мөн нийт бүртгэлтэй 25,120 ажил хайгчдаас 209 иргэн тус тус судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдсан иргэдийн ерөнхий мэдээлэл нь дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Ерөнхий мэдээлэл /хувь/

	Ерөнхий мэдээлэл	Мэргэжилтэн	Ажил олгогч	Ажил хайгч	Нийт
Хүйс	Эрэгтэй	17.9	22.8	42.6	29.7
	Эмэгтэй	82.1	77.2	57.4	70.3
Насны бүлэг	24 хүртэлх	1.9	5.3	14.4	8.0
	25-34	22.2	30.7	45.9	34.4
	35-44	48.8	42.1	29.7	39.0
	45-54	24.1	14.0	9.1	15.3
	55-аас дээш	3.1	7.9	1.0	3.3
	Бага	0.0	0.0	1.4	0.6
Боловсролын түвшин	Бүрэн дунд	0.0	7.0	31.1	15.1
	Тусгай мэргэжлийн дунд	0.0	0.9	1.9	1.0
	Техникийн мэргэжлийн дунд	0.0	0.0	8.1	3.5
	Бакалавр	75.9	74.5	51.7	65.2
	Магистр	24.1	17.5	5.7	14.6
	Нийт	100	100	100	100

Дээрх дүнгээр бүх бүлэгт эмэгтэйчүүд илүү түлхүү оролцоотой байгааг харуулж байна. Насны бүлгийн хувьд авч үзвэл мэргэжилтнүүдийн 35-44 насныхан хамгийн өндөр буюу 48.8% харин ажил олгогчдын хувьд ч мөн насны иргэд 42.1% байна. Ажил хайгч иргэдийн хувьд залуучууд буюу 25-34 насныхан 45.9%-ийг бүрдүүлж байна.

Ажил хайж буй иргэдийн 2 хүн тутмын 1 нь залуу насныхан байгаа нь залуучууд хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх эрмэлзэлтэй байгааг илтгэнэ. Боловсролын түвшний хувьд Мэргэжилтнүүдийн 75.9% нь, ажил олгогчдын 74.5% нь бакалаврын зэрэгтэй байна. Харин ажил хайгчдын 51.7% нь бакалавр, 31.1% нь бүрэн дунд боловсролтой иргэд байна. Үүнээс харахад “И-жоб” платформ хэрэглэгчдийн боловсролын түвшин өндөр байгааг харуулж байна.

Бид хэрэглэгчийн сэтгэл ханамжийг “И-жоб” платформын бүтэц үйл ажиллагаанд өгсөн “Ерөнхий үнэлгээ”, “Бусдад санал болгох эсэх” болон “Мэргэжилтний сэтгэл ханамж” гэсэн гурван үзүүлэлтээр хэмжлээ. Өгөгдөл нь гурван бүлэг хэрэглэгч буюу 209 ажил хайгч, 114 ажил олгогч, 162 мэргэжилтний мэдээллээс бүрдэнэ. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нас, хүйс, боловсрол, туршлага зэрэг нийгэм эдийн засгийн хүчин зүйлс, бүртгүүлсэн огноо, төхөөрөмж, хэзээ хамгийн сүүлд ашигласан зэрэг хэрэглээтэй холбоотой хүчин зүйлсээс хамааруулан шинжилсэн.

БҮЛЭГ 3. МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЕРӨНХИЙ ШИНЖ ЧАНАР

Судалгаанд цахим ажил зуучлалын “И-жоб” платформ хэрэглэгч болох бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч нарын төлөөлөл аймаг/дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн 98 (60.5%), сум/хорооны хөдөлмөр, халамж үйлчилгээ хариуцсан албан тушаалтын 64 (39.5%) албан хаагчид хамрагдсан байна. Албан тушаалаар нь авч үзвэл газар хэлтсийн дарга 28 (17.3%), мэргэжилтэн 134 (82.7%) хамрагдсан.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн ерөнхий шинж чанар

Ерөнхий шинж чанар		N	
Газар, хэлтэс	Аймаг, дүүрэг	98	60.5%
	Сум, хороо	64	39.5%
Албан тушаал	Газар/хэлтсийн дарга	28	17.3%
	Мэргэжилтэн	134	82.7%
Албан тушаалын нэр	Ажилд зуучлал хариуцсан мэргэжилтэн	15	11.2%
	Хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрны шилжилт хөдөлгөөн хариуцсан мэргэжилтэн	9	6.7%
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн	31	23.1%
	Ажил мэргэжлийн чиг баримжаа хариуцсан мэргэжилтэн	15	11.2%
	Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	63	47.0%
	Программ хангамж, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн	1	0.8%
	Total		100%

3.1 Хэрэглэгчийн анкет, ажил зуучлал


Энэхүү бүлэгт ажилд зуучлал хариуцсан мэргэжилтэн, ажил мэргэжлийн чиг баримжаа хариуцсан мэргэжилтэн, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан 92 мэргэжилтнүүдийн хариултад үндэслэн хийсэн тооцооллын үр дүнг харуулна. Тэдний үндсэн үүрэг нь хөдөлмөрийн зах зээл дэх ажил олгогч болон ажил хайгчдын хоорондын мэдээллийн тэнцвэрийг хангах, иргэдийн мэргэжлийн чиг баримжааг зөв тодорхойлох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршдог бөгөөд дараах үүрэгтэйгээр “И-жоб” платформыг ашигладаг.

Ажилд зуучлал, ажил мэргэжлийн чиг баримжаа болон хөдөлмөр эрхлэлт, халамжийн мэргэжилтнүүд мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах, зөвлөгөө өгөх, ажил хайгч болон ажил олгогчийг холбох, сургалт хөгжлийн боломж санал болгох, нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиг үүрэгтэйгээр “И-жоб” платформ дээр оролцдог. Энэ нь хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн баазыг бүрдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

3.1.1 Хэрэглэгчийн анкет, бүртгэл

Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэдээллийг бий болгох “И-жоб” платформын хэрэглэгчийн бүртгэл, анкет бөглөх үйл ажиллагааны үр дүнг тус бүлэгт орууллаа.


Зураг 1. Хэрэглэгчийн бүртгэл, анкет /хувь/



“Хэрэглэгчийн бүртгэл үүсгэх алхам ойлгомжтой эсэх” гэсэн үзүүлэлт дээр судалгаанд оролцогчдын 41.3% нь сайн ба түүнээс дээш үнэлсэн нь хэрэглэгч бүртгэлийн алхмыг ойлгомжтой гэж дүгнэж байгааг харуулж байна. “Хэрэглэгчийн давхардлыг хангах байдал”-ыг оролцогчдын 41.3% нь сайн ба түүнээс дээш гэж үнэлсэн нь системийн давхардал илрүүлэх механизм сайн ажиллаж байгааг харуулж байна. “Хэрэглэгчийн анкет, мэдээлэл оруулах алхам тохиромжтой эсэх” дээр 31.5% сайн ба түүнээс дээш гэж үнэлжээ.

“И-жоб” платформын хэрэглэгчийн бүртгэл, анкет бөглөх үйл ажиллагааг ихэнх хэрэглэгчид ойлгомжтой бөгөөд боломжийн гэж үнэлсэн боловч тодорхой хэсэг нь хүндрэлтэй байгааг дурдсан байна. Тухайлбал, анкет бөглөх алхмыг дунд түвшинд үнэлсэн хэрэглэгчдийн хувь өндөр байгаа нь хэрэглэгчийн зааварчилгааг сайжруулах, бүртгэл үүсгэх алхмуудыг илүү ойлгомжтой болгох шаардлагатайг харуулж байна.

Зураг 2. Хэрэглэгчийн бүртгэлд тулгардаг асуудлууд /хувь/




3.1.2 Ажил зуучлал

Ажилд зуучлал хариуцсан мэргэжилтэн нар нь хөдөлмөрийн зах зээл дэх ажил олгогч болон ажил хайгчдын хоорондын мэдээллийн тэнцвэрийг хангах үүрэгтэйгээр оролцоно.

- Ажил олгогчдоос ирүүлсэн нээлттэй ажлын байрны мэдээллийг платформ дээр байршуулж, мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулах;
- Ажил хайгчийн анкет, намтар, бүртгэлийн мэдээллийг үнэлж, тохирох ажлын байранд зуучлах;
- Сонгон шалгаруулалт, ярилцлагад оролцоход дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх;
- Платформоор дамжуулан ажил хайгчид болон ажил олгогчдын харилцааг хялбаршуулах.

Зураг 3. Ажил зуучлал /хувь/



Цахим системд сонгох боломжтой эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийг ажил мэргэжлийн ангилал тодорхойлолтод тусгагдсанаар шинэчлэх, нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн саналыг мэргэжилтнүүд хэлж байсан. Судалгаанд оролцогчдын дөрөвний гурав нь хадгалагдсан ажлын байрны нэр, ангилал ашиглахад тохиромжтой байдал гэдэгт дундаас доош үнэлгээ өгсөн нь уг саналыг нухацтай авч үзэх шаардлагатайг харуулж байна.

“Ажилд зуучлах үйл явцыг системээр дамжуулж хянах, мэдээлэх боломж”-ийг тодорхойлох үзүүлэлтийг оролцогчдын 50.0% нь дунд зэрэг гэж үнэлжээ. Харин 32.7% нь сайн ба түүнээс дээш гэж үнэлсэн. Үр дүнгээс харахад системийн хяналт, мэдээлэл дамжуулалт нь дунд түвшинд үнэлэгдэж байгаа бөгөөд тодорхой хэсэг нь сайн гэж үзсэн ч “Маш сайн” гэсэн үнэлгээ бага байна. Аль аль үзүүлэлт дээр оролцогчдын 50-55% нь “Дунд зэрэг” гэж үнэлсэн. Харин “Сайн”, “Маш сайн” гэж үнэлсэн хувь тодорхой хэмжээнд байгаа ч үнэлгээ маш бага байгаа нь үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

Зураг 4. Ажлын байрыг нэрээр хайхад үүсдэг асуудал /хувь/



Судалгааны үр дүнгээр ажлын байрны нэршлээр хайлт хийхэд хамгийн хүндрэлтэй байгаа асуудлын үндсэн шалтгаан нь мэдээллийн систем дэх мэргэжлийн нэршлийн шинэчлэлт хангалтгүй болон ЭЗҮА-ны салбараар мэргэжлийн зөрүү байгаагаас үүссэн гэж харж байна. Мөн хэрэглэгчийн хайлтын сонголтуудын хүртээмжтэй холбоотой хүндрэлүүд гарч байгаа нь ажлын байрны мэдээллийн системийг илүү боловсронгуй болгох, нэршлийн нэгдсэн стандарт бий болгох шаардлагатайг харуулж байна. Мөн мэргэжилтнүүдээс “И-жоб” платформын талаарх санал хүсэлт авахад “ААНБ болон ажил мэргэжлийн нэршлийг шинэчлэх, нэмэгдүүлэх” гэсэн асуудал нь олон давтагдан гарч байсан нь уг саналыг нухацтай авч үзэх шаардлагатай байгааг илтгэж байна.

Зураг 5. Ажилд зуучлах үйлчилгээний хамгийн их ажиллагаатай үе шат /хувь/



Ажил зуучлах үйлчилгээнд хамгийн их ачаалал үүсгэж буй асуудлаар оролцогчдын 14.4% нь “Ажил хайгчийн бүртгэл үүсгэх” үйл ажиллагааг сонгосон нь тухайн бүртгэл үүсгэх үйл явцыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Мөн “Зуучлах үйл явцыг хянах” үзүүлэлт 13.9% байгаа бөгөөд ажил хайгч болон ажил олгогчийн тохирох ажлын байранд холбогдох шатанд ихээхэн хүндрэл, ачаалал байдаг болохыг илтгэж байна.

Үүнээс харахад ажилд зуучлах үйлчилгээнд хамгийн их ачаалал үүсгэдэг үе шат нь ажил хайгчийн бүртгэл, ажлын байрны захиалга, санал болгох болон үйл явцыг хянах шатнууд байна. Харин баталгаажуулалт, тайлан гаргах, нэмэлт үйлчилгээ үзүүлэх зэрэг шатны ажлууд харьцангуй бага ачаалалтай байгаа нь харагдаж байна.

Зураг 6. “И-жоб” платформын ажиллагаа их шаарддаг шалтгаан /хувь/



Ажилд зуучлах үйлчилгээнд хамгийн их ачаалал үүсгэдэг асуудлын шалтгааныг нь тодруулбал 29.7% нь “Бүх мэдээллийг гараар шивж оруулдаг”, харин 25.1% нь “Систем доторх мэдээлэл солилцоо хангалтгүй учир” гэсэн хариултыг сонгосон байгаа бол 18.3% нь “Системд оруулсан мэдээллийг дахин оруулдаг” гэсэн асуудлыг дурдсан нь анхаарал татахуйц байна. Үүнээс харвал системийн үзүүлэлт хоорондын уялдаа холбоо мэдээлэл солилцох байдал муу мөн хадгалагдах байдал сул байгаа гэдгийг харж болох юм.

Зураг 7. Ажилд зуучлал амжилтгүй болдог шалтгаан /хувь/



Ажилд зуучлал амжилтгүй болдог шалтгааны 32.2% нь “Программын ажиллагаа хангалтгүй байдал”-ын нөлөө байгаа нь системийн найдвартай ажиллагаа, техникийн асуудал нь хамгийн том саад болж буйг харуулж байна. Мөн мэргэжилтнүүдээс дээрх саналыг асуудлын хүрээнд тодруулахад “Ажил олгогчийн захилгад тохирсон ажил хайгчийг системд автоматаар санал болгодог болгох болон ажил хайгчийн боловсрол, ур чадвар, туршлагад нийцсэн ажлын байрыг санал болгох” гэсэн саналууд их дурдагдсан нь программын энэ талын ажиллагааг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Оролцогчдын 30.1% нь “Ажил хайгч ажлын байрны шаардлага хангахгүй байдал”-ыг сонгосон нь тухайн ажил горилогчдын ур чадвар, туршлага нь ажлын байрны шаардлагатай нийцэхгүй байгаа шалтгаан болж байна. Үүнээс харахад ажлын байрны шаардлага, ажил хайгчийн ур чадварыг тодруулсан үзүүлэлтээр системийн мэдээллийг баяжуулах нь ажилд зуучлах ажлын үр дүнг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

БҮЛГИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

“Ажилд зуучлал, ажил мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд “И-жоб” платформыг ашиглан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийг нэгтгэн хүргэж, ажил хайгч ба ажил олгогчийг холбох чухал үүрэг гүйцэтгэж байна. Судалгааны үр дүнгээс харахад системийн хэрэглээ, бүртгэл, анкет бөглөх, ажлын байрны мэдээлэл болон зуучлалын үйл явцын үнэлгээ дунд түвшинд давамгайлж байгаа бөгөөд хэрэглэгчдийн тодорхой хэсэг нь бүртгэл хийх болон мэдээлэл хайх нь хүндрэлтэй байгааг илэрхийлсэн байна.

Хамгийн их тулгамдаж буй асуудал нь хэрэглэгчид цахимаар өөрсдөө бүртгүүлэхээс илүүтэй мэргэжилтнээр дамжуулан бүртгүүлэхийг илүүд үзэж байгаа нь хэрэглэгчийн цахим чадвар болон системийн ойлгомжтой байдалд анхаарах шаардлагатайг харуулж байна. Мөн ажил зуучлагчдын системийг ашиглах чадвар харилцан адилгүй байгаа нь үйл ажиллагаанд хүндрэл үүсгэж байна. Системийн дотоод мэдээлэл солилцоо, хадгалах чадвар сул, мэдээллийн ангиллын зөрүү, хайлтын үр дүнгийн бүрэн бус байдал нь ажлын байрны мэдээллийн хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

3.2 ХЭДХ, арга хэмжээ АМЧБОУ

Энэхүү бүлэгт Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүдийн мэдээллээр үр дүнг боловсруулсан.


Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн нь иргэдийн мэдээллийг бүртгэх, тайлагнах, дүн шинжилгээ хийх, уялдаа холбоо хангах зорилгоор “И-жоб” платформыг ашигладаг бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн “И-жоб” платформд өгөгдөл бүртгэх, тайлагнах, хяналт шинжилгээ хийх, нэгдсэн мэдээлэл гаргах үндсэн үүргээр оролцдог бөгөөд энэ нь бодлого боловсруулах, хэрэгжилтийг үнэлэхэд чухал ач холбогдолтой.

3.2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр

Судалгаанд хамрагдсан хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нар нь дараах үүрэгтэйгээр “И-жоб” платформыг ашигладаг.

- Платформоор дамжуулан нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг бүртгэж, хөдөлмөр эрхлэлтийн болон халамжийн үйлчилгээтэй холбох;
- Төрөөс хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл, сургалтын мэдээллийг хүргэх, хамруулах;
- Иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн болон халамжийн бодлогын талаарх мэдээлэл, зөвлөгөөг цахимаар өгөх;
- Нийгмийн хамгааллын үйлчилгээг ил тод, хүртээмжтэй байлгах зорилгоор платформын мэдээллийг шинэчилж, хэрэглэгчидтэй харилцах.


Зураг 8. ХЭД төсөл хөтөлбөрийн талаарх мэдээлэл платформд бүрэн байдаг эсэх /хувь/



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдахад шаардлагатай мэдээ мэдээлэл платформд бүрэн байршдаг талаар тодруулахад оролцогчдын 57.1% нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл байдаг гэж хариулсан боловч 42.9% нь “Үгүй” гэж үзсэн нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн талаарх хөтөлбөр

арга хэмжээний талаар болон бусад холбогдох мэдээлэл бүрэн байрлаагүй, мэдээлэл хангалттай иргэдэд хүрдэггүй, нэгдсэн байдлаар байрлаагүй гэж үзэж байгааг харуулж байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг платформд бүрэн байршуулж ил тод, хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийг нэгтгэн хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар хүргэх шаардлагатайг харуулж байна.

Зураг 9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр /хувь/



“И-жоб” платформд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний үйлчилгээ нэвтэрснээр хэрэглэгчдэд “ХЭДХ, арга хэмжээний мэдээлэл хэрэгцээтэй, хүртээмжтэй байдал”-ыг онооны өсөх эрэмбийн үнэлгээгээр 1-5-ын хооронд үнэлүүлэхэд 17.9% нь 1 буюу “Маш муу” гэсэн хариултыг сонгосон байгаа бол 5 буюу “Маш сайн” гэсэн хариулт 0 хувь байгаа нь энэ талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх байдлыг сайжруулах нэн шаардлагатайг харуулж байна. Мөн “Мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь хүргэж чадах байдал” гэсэн асуултыг тодруулан асуухад “Маш сайн” гэсэн үнэлгээ 0 хувьтай байгаа нь дээрх үр дүнг дахин нотолж байгаа юм.

Зураг 10. ХЭДХ, арга хэмжээний талаарх мэдээллийг шинэчлэх давтамж /хувь/



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг шинэчлэх давтамжийг мэргэжилтнүүдээс тодруулахад судалгаанд оролцогчдын 32.1% нь сар тутам, 28.6% нь 7 хоног тутам шинэчилдэг гэсэн хариултыг өгсөн.

Зураг 11. ХЭДТХ, арга хэмжээнд хамрагдсан иргэдийн бүртгэл мэдээллийг хөтлөхөд үүсдэг асуудал/ хувь/




Хөтөлбөр арга хэмжээнд хамрагдсан иргэдийн бүртгэл мэдээллийг хөтлөхөд гарч буй асуудлын хүрээнд “Систем дэх мэдээллийг дахин шивэх” болон “Иргэний мэдээлэл дутуу байх” асуудал нь хамгийн их тохиолддог гэж үзсэн байна. Харин иргэний бүртгэл давхцах тохиолдол байдаг гэж 18.8% нь хариулсан байна. Иргэдийн бүртгэл, мэдээлэлтэй холбоотой хамгийн том хүндрэл нь мэдээллийн давхардал болон дутуу байдал, үүнээс үүдсэн мэдээллийг дахин шивэх асуудал үүсдэг байна. Энэ нь мэдээллийн системийн уялдаа холбоо сул, бүртгэлийн чанар хангалтгүй байгааг харуулж байгаа бөгөөд цаашид нэгтгэсэн, алдаагүй мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл шивэх ажлыг автоматжуулах шаардлагатайг илтгэж байна.

3.2.2. Ажил мэргэжлийн чиг баримжаа

Ажил мэргэжлийн чиг баримжаа хариуцсан мэргэжилтэн нь дараах үүрэгтэйгээр “И-жоб” платформыг ашиглана.

- Платформын хэрэглэгч ажил хайгчдад өөрийн сонирхол, ур чадвараа тодорхойлох тест, үнэлгээний хэрэгсэл ашиглан зөвлөмж өгөх;
- Зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжил, ур чадварын талаарх мэдээлэл, зөвлөгөөг цахимаар хүргэх;
- Хэрэглэгчийн боловсрол, мэргэжлийн сонголттой уялдуулан сургалт, хөгжлийн боломжийг санал болгох;
- Карьер төлөвлөлтийн цахим зөвлөгөөг тогтмол үзүүлж, ажил мэргэжлийн чиг баримжааг оновчтой тодорхойлоход дэмжлэг үзүүлэх.

Зураг 12. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ /хувь/



Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хувьд “И-жоб” платформд нэвтэрснээр “Ажил мэргэжлийн зөвлөгөө авах хүсэлтийг цахимаар авах, нэгтгэх” үйл явц хэр зэрэг хялбар болсон талаар тодруулахад оролцогчдын 77.2% нь дунд ба түүнээс доош гэж үзсэн. Хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ буюу “Профайлинг”-ыг систем дээр хийх үеийн сэтгэл ханамжийг тодруулбал оролцогчдын мөн 77.2% нь дунд ба түүнээс доош гэж үзсэн байна. Мэргэжилтнүүд хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ буюу “Профайлинг” үйлчилгээний давхардсан, хүндрэлтэй асуултыг хасах, профайлингийн асуулгыг хялбарчлах гэсэн санал олон давхцаж байсан нь энэ асуудалд анхаарах шаардлагатай, системд хүндрэл байгааг илтгэж байна.


Зураг 13. Сэтгэл ханамжгүй байх шалтгаан /хувь/



Хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ буюу “Профайлинг”-г систем дээр гүйцэтгэхэд мэргэжилтнүүдийн сэтгэл ханамжгүй байгаа шалтгааны 58.4% нь “Хэт олон асуулттай тул үнэлгээнд оролцогч залхдаг” гэсэн байгаа нь үнэлгээ, судалгааны асуулгын бүтэц хэт урт, төвөгтэй байгааг харуулж байна.

Үүнээс харахад үнэлгээний асуулгыг оновчтой болгох, асуултын тоог цөөрүүлж, товч бөгөөд тодорхой байдлаар боловсруулах шаардлагатай. Энэ нь оролцогчдын идэвх, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Зураг 14. АМЧБОУ-г илүү үр дүнтэй болгохын тулд хийх өөрчлөлт /хувь/



Иргэдийн 24.3% нь зөвлөгөө, мэдээлэл авах бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлэх шаардлагатай гэж үзсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Харин 22.5% нь чатбот нэвтрүүлэхийг чухалчилж, хэрэглэгчидтэй түргэн шуурхай харилцах боломжийг онцолжээ. Иргэдийн хувьд зөвлөгөө авах үйлчилгээг илүү хүртээмжтэй, хурдан, олон сонголттой болгохын тулд цахимжуулалт, автоматжуулалт (цахим бүртгэл, чатбот, цахим зөвлөгөө) болон мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Энэ нь үйлчилгээний чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх гол хүчин зүйл болохоор байна.

БҮЛГИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүдийн “И-жоб” платформ ашиглалт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийг нэгтгэн хүргэх, иргэдийн ур чадвар, сонирхолд нийцсэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ хийх чухал ач холбогдолтой. Судалгааны үр дүнгээс харахад, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл платформд бүрэн байрласан гэж мэргэжилтнүүдийн 57.1% үзэж байгаа ч мэдээлэл дутуу эсвэл хүртээмж муутай гэж дүгнэсэн нь 42.9% бүрдүүлж байсан нь мэдээллийн ил тод байдал, нэгдсэн байдлыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Мөн иргэдийн бүртгэл, мэдээлэлтэй холбоотой хамгийн том хүндрэл нь мэдээллийн давхардал болон дутуу байдал байгаа нь системийн уялдаа холбоо сул байгааг илтгэнэ. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хувьд (50.0%) цахим систем нэвтэрснээр тодорхой ахиц мэдрэгдээгүй гэж үзэж байгаа бөгөөд профайлинг үнэлгээний асуулга хэт урт, төвөгтэй, хугацаа их шаарддаг нь оролцогчдын идэвх, сэтгэл ханамжийг бууруулж байна.

Цаашид зөвлөгөө, мэдээллийг илүү хүртээмжтэй болгохын тулд иргэд цахим бүртгэл, чатбот нэвтрүүлэх, олон төрлийн цахим зөвлөгөө, мэдээллийн сонголтыг нэмэгдүүлэхийг чухалчилсан нь үйлчилгээг


цахимжуулж, автоматжуулах, хэрэглэгчийн интерфэйсийг хялбарчлах, мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатайг тодорхой харуулж байна.

3.3 Тайлан, мэдээ ашиглалт

Тус бүлэгт нийт аймаг, дүүрэг, сум хороодын хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/хэлтсийн дарга болон мэргэжилтэн нараас авсан судалгааны мэдээллийн үр дүн хамаарах бөгөөд “И-жоб” платформын тайлан мэдээг бүрдүүлэх, ашиглах үйл ажиллагаанд тус бүрийн чиг үүргийн хүрээнд оролцдог.


Газар/хэлтсийн дарга нар бодлого, удирдлага, хяналтын түвшинд ажиллаж харин мэргэжилтнүүд мэдээ бүртгэл, тайлан боловсруулах, дүн шинжилгээ хийхэд голчлон оролцдог. Тайлан, мэдээ ашиглалттай холбоотойгоор газар, хэлтсийн дарга болон мэргэжилтнүүдийн сэтгэл ханамж, тулгардаг хүндрэл бэрхшээлийн талаар дараах үр дүнгүүдийг гаргалаа.

Зураг 15. Хэрэглэгчийн бүртгэлийн тайлан, мэдээ гаргах байдал /хувь/




Хэрэглэгчийн бүртгэлийн тайлан, мэдээ гаргах үйл явцын хүндрэлтэй байдлыг газар/хэлтсийн дарга болон мэргэжилтний түвшинд харьцуулан үнэлэхэд дараах үр дүн гарсан. Судалгаанд хамрагдсан хоёр бүлгийн /газар, хэлтсийн удирдлагын 53.6%, мэргэжилтнүүдийн 50.0%/ дийлэнх нь мэдээ гаргах явцын үйл ажиллагааг “Дунд зэрэг” гэж үнэлсэн байна. Харин “Хүндрэлтэй” гэж үзсэн дарга нар 21.4%-ийг, мэргэжилтнүүд 22.4%-ийг бүрдүүлж байна.

Зураг 16. Үүсдэг хүндрэл бэрхшээл /хувь/



“И-жоб” платформын тайлан, мэдээг боловсруулахад тулгамддаг нийтлэг хүндрэл нь дараах байдлаар тодорхойлогдож байна. Нэгдүгээрт, газар/хэлтсийн удирдлагын 33.3%, мэргэжилтнүүдийн 25.6% нь платформд хадгалагдсан мэдээлэл зөрүүтэй татагддаг гэж үзсэн нь хамгийн түгээмэл тулгардаг асуудал болохыг харууллаа. Хоёрдугаарт, мэргэжилтнүүдийн 28.7% нь хадгалсан мэдээллийг тайланд ашиглах боломжгүй гэж үзсэн нь удирдлагын 20.0%-ийн үзүүлэлтээс өндөр байна. Энэ нь мэргэжилтнүүдийн хувьд мэдээллийн чанар, ашиглалт илүү их хүндрэл дагуулж буйг илтгэнэ. Удирдлагын түвшинд болон мэргэжилтэн нарт мэдээллийн зөрүүгээс бий болсон асуудал нь хамгийн их хүндрэл болж тухайн мэдээллийг ашиглах боломжгүй байдал нь үйл ажиллагаанд илүү тод илэрдэг байна.

Зураг 17. Мэдээллийн хадгалагдах байдал /хувь/



Судалгааны дүнгээр мэдээллийн хадгалагдах байдлыг үнэлэхэд газар/хэлтсийн дарга нар болон мэргэжилтнүүдийн дунд тодорхой ялгаа ажиглагдаж байна. Газар/хэлтсийн удирдлагын 39.3% нь мэдээлэл хадгалагдах байдал хангалтгүй буюу нийцдэггүй гэж үзсэн бол мэргэжилтнүүдийн хувьд энэ үзүүлэлт 12.7% байна. Энэ нь удирдлагын түвшинд мэдээллийн хүртээмж, чанарын асуудал илүү хурцаар мэдрэгдэж буйг илтгэнэ. Нөгөө талаас, мэргэжилтнүүдийн 54.5% нь мэдээллийн хадгалагдах байдлыг дунд зэрэг гэж үнэлсэн нь удирдлагын 25.0%-ийн үнэлгээнээс хоёр дахин өндөр үзүүлэлттэй байна. Ерөнхийд нь харахад, газар/хэлтсийн дарга нар мэдээллийн хадгалагдах байдлыг хангалтгүй гэж илүү ихээр үнэлсэн бол мэргэжилтнүүдийн дийлэнх нь дунд зэрэг гэж үзсэн байна. Энэ нь мэдээллийн хадгалагдах байдал нь үйл ажиллагааны хүрээнд хүртээмж, нийцлийн талаарх ойлголт, мэдрэмж нь удирдлагын түвшин болон гүйцэтгэх түвшинд ялгаатай байгааг харуулж байна.


Зураг 18. Мэдээллийн хадгалагдах байдал хэрэгцээнд нийцдэггүй шалтгаан /хувь/



Судалгааны үр дүнд хэрэглээнд нийцэхгүй байгаа гол шалтгаануудыг газар/хэлтсийн дарга болон мэргэжилтнүүдийн үнэлгээгээр харьцуулан авч үзлээ. Газар/хэлтсийн удирдлагын зүгээс 22.0% нь “Хадгалсан мэдээллийн систем доторх шилжилт, уялдаа хангалтгүй” гэсэн үзүүлэлт хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол мэргэжилтнүүдийн хувьд 21.2% нь “Үйлдэл бүрээр хадгалах нь төвөгтэй” гэсэн үзүүлэлт хамгийн өндөр хувийг эзэлжээ.


Энэ бүхнээс харахад Удирдлагын түвшинд мэдээллийн чанар, давхардал, нийцлийн асуудал гол анхаарал татаж байгаа бол гүйцэтгэгч түвшинд мэдээллийн хэрэглээний хялбар байдал, автоматжуулалт чухалд тооцогдож байна. Иймээс мэдээллийн хадгалалт, менежментийн бодлого боловсруулахдаа стратегийн чанар (чанар, стандарт) болон ажлын хэрэгцээт үр ашиг (автоматжуулалт, хэрэглээний хялбар байдал) зэрэг хоёр үзүүлэлтийг уялдуулан авч үзэх шаардлагатай байна. Мэргэжилтнүүдээс санал хүсэлтийг талаар тодруулахад дээрх асуудлууд давтагдан гарч байсан нь энэ тал дээр анхаарах шаардлагатай илтгэж байна.

Зураг 19. Платформын процесс хоорондын уялдаа /хувь/



Платформын процессын уялдааг үнэлэхэд мэргэжилтнүүдийн хувьд 80.6% нь дунд ба түүнээс доош гэж үнэлсэн байгаа бол газар, хэлтсийн удирдлагын хувьд 67.9% дунд ба түүнээс доош гэж үнэлсэн байна. Үүнээс харахад байгууллагын мэдээллийн хадгалалт болон платформын процессын уялдааны асуудал стратегийн түвшинд (чанар, стандарт, давхардалгүй байдал) болон ажлын хэрэгцээний түвшинд (автоматжуулалт, хэрэглээний хялбар байдал) өөр өөрөөр илэрч байна. Удирдлагын түвшинд мэдээллийн чанар, найдвартай байдалд илүү ач холбогдол өгч байгаа бол, мэргэжилтнүүдийн хувьд ажлын гүйцэтгэл, хялбар байдлыг чухалчилж байна. Тиймээс мэдээллийн удирдлага, платформын хөгжүүлэлтийн бодлого боловсруулахдаа хоёр талын хандлагыг уялдуулан, чанар ба стандартын баталгааг хангахын зэрэгцээ хэрэглээний төвөггүй, автоматжуулсан шийдлийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.


Зураг 20. Уялдааг хэрхэн сайжруулах вэ? /хувь/



Судалгааны үр дүнгээс харахад байгууллагын мэдээллийн уялдааг сайжруулахад удирдлага болон мэргэжилтнүүд өөр өөрийн байр суурийг илэрхийлсэн боловч нийтлэг чиг хандлага тодорхой ажиглагдаж байна. Ижил “мэдээллийг дахин шивэх шаардлагагүй болгох” гэсэн үзүүлэлт газар, хэлтсийн дарга болон мэргэжилтэн нарын хувьд ялгаагүй өндөр хувьтай байгаа нь энэхүү асуудал дээр анхаарах шаардлага байгааг харуулж байна.

Удирдлагын түвшинд мэдээллийн давхардлыг арилгах, системийн бүтцийг оновчтой болгох чиглэлд анхаарч байгаа бол мэргэжилтнүүдийн түвшинд ажлын урсгал доторх мэдээлэл солилцоог өргөжүүлэх шаардлага хамгийн өндөр байна. Тиймээс мэдээллийн уялдааг сайжруулах бодлогыг боловсруулахдаа дээрх хоёр чиглэлийг уялдуулан, системийн бүтцийг оновчтой болгож, өдөр тутмын хэрэглээний түвшинд мэдээлэл солилцооны үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.


Зураг 21. Орон нутгийн түвшинд дүн шинжилгээ хийх боломж /хувь/



Удирдлагын олонх нь платформд орон нутгийн түвшинд дүн шинжилгээ хийх хангалттай боломж байна гэж үзэж байгаа бол мэргэжилтнүүдийн дунд арай бага хувь нь эергээр үнэлсэн ч удирдлага болон мэргэжилтнүүдийн хувьд орон нутгийн түвшинд дүн шинжилгээ хийх боломж


хийх боломж хязгаарлагдмал гэж үзэж буй зөрүү мөн ажиглагдаж байна.

Зураг 22. Боломжгүй байдаг шалтгаан /хувь/



Орон нутгийн түвшинд дүн шинжилгээ хийх нь яагаад боломжгүй байгааг тодруулахад газар/хэлтсийн удирдлагын хувь 50.0% нь “Механик ажиллагаа их ордог” гэсэн сонголт дийлэнх хувийг эзэлж байгаа бол мэргэжилтнүүдийн хувьд 36.4% нь “Шаардлагатай мэдээ, тайлан ашиглах эрх хязгаарлагдмал” гэсэн хариултыг сонгожээ. Тоо мэдээлэл нэгтгэж гаргах эрх нь зөвхөн газар/хэлтсийн даргад байдаг нь мэргэжилтэн нарт тоо мэдээлэл ашиглах дүн шинжилгээ хийх боломжийг бууруулдаг байсан нь энэ асуудал дээр анхаарч сайжруулах шаардлагатайг харуулж байна.


Зураг 23. Ажлын цагийн хэмнэлт /хувь/



Судалгаанд оролцогчдын хамгийн өндөр хувь нь ажлын цагийн хэмнэлт мэдэгдэхүйц гараагүй гэж үзсэн байна. Ялангуяа удирдлагын түвшинд ажлын ачаалал өмнөхөөс нэмэгдсэн гэж үзэх хувь илүү байна. Судалгаанд оролцогчдын гуравны нэг орчим нь ажлын цагийн хэмнэлт огт гараагүй гэж үзсэн нь системийн үр ашиг тодорхой хэмжээнд хүлээлтэд хүрээгүй байгааг харуулж байна. Удирдлагын түвшинд зарим тохиолдолд ажлын цаг нэмэгдсэн гэж үзэж байгаа нь системийн үр өгөөж бодлого хэрэгжүүлэх шатанд бүрэн тусахгүй байгаагийн шинж байж болох юм. Хэдийгээр зарим оролцогчид 30 минутаас 2 цаг хүртэл цагийн хэмнэлт гарсан гэж үзэж байгаа боловч нийт судалгааны дүнгээр энэ нь бага хувийг эзэлж байна. Иймээс цаашид системийн үр ашгийг нэмэгдүүлэхэд процессын оновчтой шинэчлэл, автоматжуулалт, хэрэглэгчийн дадлагажуулах зэргийг ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

3.4 “И-жоб” платформын сэтгэл ханамж

Зураг 24. Хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хялбар, оновчтой, шуурхай шийдвэрлэж буй байдал /хувь/



Хөдөлмөр эрхлэлтийн дээр асуудлуудыг “И-жоб” платформоор дамжуулж хялбар, оновчтой, шуурхай шийдвэрлэж байгаа байдлыг 1-5-ын хооронд буюу “Маш муу”, “Муу”, “Дунд”, “Сайн”, “Маш сайн” гэсэн үнэлгээгээр үнэлэхэд дээрх үр дүн гарч байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд оролцогчдын 26.5% нь “Сайн” ба 35.8% нь “Дунд” гэж үнэлсэн. Хамгийн өндөр сэтгэл ханамжтай биш ч голч үнэлгээ давамгайлсан. Мэргэжлийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох “Дунд” 45.1%, “Сайн” 19.1% байгаа нь сайжруулах шаардлагатайг харуулж байна. Статистик, тоон мэдээлэл, тайлан ашиглах, хэрэглэх “Дунд” 45.7%, “Сайн” 22.2% байгаа нь мөн адил түвшинд байна. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлын үр дүнг “Сайн” 32.1% ба “Дунд” 34.6%-иар үнэлсэн нь энэ тухайн ажил хамгийн өндөр “Сайн” үнэлгээтэй үйлчилгээний нэг байна. Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг 30.9% “Сайн”, 44.4% “Дунд” гэж үнэлсэн нь сэтгэл ханамжийн хувьд боломжийн үнэлгээтэй үйлчилгээ байна. Ажил зуучлалыг мэргэжлийн үйлчилгээгээр үзүүлэх үйлчилгээг 28.4% “Сайн” ба 36.4% “Дунд” түвшинд үнэлсэн. Хувийн хөдөлмөрийн биржтэй мэдээлэл солилцох ажлыг “Сайн” 21.6% ба “Дунд” 35.8% үнэлж байгаа нь голч үнэлгээ давамгайлсан үр дүн байсан. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг хүргэхийг нэмэгдүүлэх ажлыг 49.4% “Дунд”, 21.6% “Сайн” гэж үнэлсэн ч оролцогчдын 16.0% нь “Муу” гэж үнэлсэн.

Ихэнх үйлчилгээний хувьд “Маш муу” гэсэн үнэлгээ бага байгаа (4-7%), “Дунд” ба “Сайн” түвшний үнэлгээ нийт хариултын 60-аас дээш хувийг эзэлдэг. Хамгийн эерэг үнэлгээтэй байгаа нь “Хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх” үйл ажиллагааны үр дүн байна.

Зураг 25. “И-жоб” платформын бүтэц, ажиллагаа, ашиглалт /хувь/




■ Бүрэн санал нийлэхгүй ■ Санал нийлэхгүй ■ Дунд ■ Санал нийлнэ ■ Бүрэн санал нийлнэ

Сайн үнэлгээтэй үзүүлэлтүүд буюу “Маш сайн”, “Сайн” гэсэн үзүүлэлтүүдийг авч үзвэл ашиглахад маш хялбар, ойлгомжтой, чиглүүлэгчтэй гэсэн үзүүлэлт дээр “Бүрэн санал нийлнэ” 12.3%, “Санал нийлнэ” 28.4%, хэрэглэгчийн мэдээллийг давхардалгүй, бүрэн удирддаг “Бүрэн санал нийлнэ” 10.5%, “Санал нийлнэ” 27.8% ийг тус тус эзэлж байна.

Харин сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдийг авч үзвэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглахад тохиромжтой гэсэн үзүүлэлт дээр “Санал нийлэхгүй” гэсэн оролцогч 27.8%, “Бүрэн санал нийлэхгүй” 14.8% нь байгаа бол ажлын ачаалал эрс багассан “Санал нийлэхгүй” 26.5%, “Бүрэн санал нийлэхгүй” 10.5% нь тус тус байна. Бүх түвшний хэрэглэгчийн механик ажиллагааг хөнгөвчилсөн гэсэн үзүүлэлтийг харвал 48.1% дунд зэрэг гэсэн хариултыг сонгосон байгаа бөгөөд бусад үзүүлэлтүүдээс хамгийн өндөр үзүүлэлтээр харагдаж байна. Энэ нь бүх түвшний хэрэглэгчийн механик ажиллагаанд өөрчлөлт ороогүй гэдгийг илтгэж байна. Дээрх үзүүлэлтүүдээс харвал давуу тал: Ашиглахад ойлгомжтой, тайлан гаргалт хурдан, хэрэглэгчийн эрхийн тохиргоо сайн байгаа бол сул тал: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлгүй, системийн уялдаа холбоо сул, профайлинг ойлгомжгүй байдал байна.

Зураг 26. “И-жоб” платформыг ашиглах үед тулгардаг хүндрэл, асуудал /хувь/



“И-жоб” платформыг ашиглах үед тулгардаг хүндрэл, асуудлуудыг 1-5 хооронд үнэлэхэд хамгийн түгээмэл тулгарч буй хүндрэл нь “Системд хандах эрх сэргээхэд хүндрэлтэй байх” гэсэн үзүүлэлт дээр “Хүндрэлтэй” 22.8%, “Маш хүндрэлтэй” 5.6% байгаа бол “Оруулсан мэдээлэл алга болох, устах, харагдахгүй байх” үзүүлэлт дээр “Хүндрэлтэй” 19.8%, “Маш хүндрэлтэй” 5.6% тус тус өндөр хувийг эзэлж байна.


Асуудалгүй байгаа үзүүлэлтийг авч үзвэл “Систем гацах, ажиллахгүй байх” 38.3% нь “Хүндрэлгүй” харин 25.3% нь “Маш хүндрэлгүй” гэсэн хариултуудыг сонгожээ. Үүнээс харахад системд гацах, ажиллахгүй байх тохиолдол харьцангуй бага харагдаж байгаа хэдий ч мэдээллийн хадгалагдах байдал устаж алга болох зэргээс гадна хандалтын эрх сэргээх процессыг хялбаршуулах, оруулсан мэдээллийн уялдаа холбоог сайжруулах зэрэг арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Зураг 27. “И-жоб” платформд сайжруулах шаардлагатай зүйлс /хувь/



“И-жоб” платформд сайжруулах шаардлагатай асуудлыг харвал “Системийн ажиллагааг илүү хурдтай болгох” гэсэн үзүүлэлт дээр оролцогчдын 24.7% нь “Санал нийлнэ”, 42.6% нь “Бүрэн санал нийлнэ” гэсэн байгаа бол “Мэдээллийн уялдаа холбоог сайжруулах” гэсэн үзүүлэлт дээр 25.3% нь “Санал нийлнэ”, 37.7% нь “Бүрэн санал нийлнэ” гэсэн хариултуудыг оролцогчид сонгосон байна. Дээрх үзүүлэлтүүдээс харвал “И-жоб” платформ хэрэглэгчид системийн хурд, найдвартай ажиллагаа, мэдээллийн уялдаа, бүрэн бүтэн байдал, хэрэглэхэд ойлгомжтой байдал, технологийн хувьд энгийн, хэрэглэгчдэд ээлтэй байдал зэргийг сайжруулахыг хүсэж байна.

Зураг 28. Эдийн засгийн хэмнэлт /хувь/



Эдийн засаг болон цаг хугацааны хувьд хэмнэлт гаргаж чадсан эсэхийг дээрх хэдэн асуултаар тодруулбал “Орон зайнаас үл хамаарч хэрэглэх бүрэн боломжтой” гэсэн үзүүлэлт дээр 29.6% нь “Санал нийлнэ”, 21.0% “Бүрэн санал нийлнэ” харин “Цаасны хэрэглээг маш их бууруулсан” гэсэн үзүүлэлт дээр 25.9% нь “Санал нийлнэ”, 14.2% “Бүрэн санал нийлнэ” гэсэн байна. Үүнээс харахад эдийн засгийн хэмнэлттэй холбоотойгоор ихэнх оролцогчид эерэг байр суурьтай байлаа. Ялангуяа цахилгаан хэрэглээний бууралт, орон зайнаас үл хамаарах боломж, цаг хугацааны хэмнэлтийн тал дээр илүү өндөр түвшинд үнэлэгдсэн байна.

Хүснэгт 3. Мэргэжилтний сэтгэл ханамж

Хувьсагчид	Сэтгэл ханамжтай		Р утга
	Тийм	Үгүй	
Эмэгтэй	0.368	0.344	0.813
Магистр ба дээш боловсролтой	0.410	0.349	0.506
35 хүртэлх насны	0.384	0.357	0.766
Улаанбаатарт амьдардаг	0.478	0.318	0.068
5 хүртэл жил ажилласан	0.406	0.336	0.376
Газар/хэлтсийн дарга	0.214	0.395	0.049
Сар тутам хэрэглэдэг	0.367	0.333	0.8

Мэргэжилтнүүдийн хувьд газрын хэлтсийн дарга болон орон нутагт амьдардаг бол “И-жоб” платформыг ажилдаа ашигласнаас авах сэтгэл ханамж нь доогуур байна. Хүйс, боловсрол, нас, ажлын туршлага болон хэр тогтмол хэрэглэдэг нь сэтгэл ханамжтай хамааралгүй байна.

“И-жоб” платформ хэрэглэгчдийн сэтгэл ханамж нь нас, боловсрол, туршлага болон байршил зэрэг нийгэм, эдийн засгийн шинж чанар, хэзээ хэрэглэсэн, хэр их хэрэглэдэг зэрэг хэрэглээтэй холбоотой үзүүлэлтүүдтэй ямар хамааралтай байгаад шинжилгээ хийлээ. Уг шинжилгээнд ажил хайгч, ажил олгогчийн хувьд бусдад санал болгох эсэх нь сэтгэл ханамжийг нь харуулна гэж үзэж, хамааран хувьсагч болгосон.

Мэргэжилтнүүдийн хувьд “И-жоб” платформыг ажилдаа хэрэглэхдээ сэтгэл ханамжтай байдаг эсэхийг хамааран хувьсагч болгосон бөгөөд 36 хувь нь сэтгэл ханамжтай гэж хариулжээ.

БҮЛЭГ 4. АЖИЛ ОЛГОГЧ, АЖИЛ ХАЙГЧ НАРЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

4.1 Ажил олгогч, ажил хайгч нарын ерөнхий шинж чанар

Ажил олгогч болон ажил хайгчдыг ерөнхий шинж чанар буюу цахим ажил зуучлалын “И-жоб” платформд бүртгүүлсэн он болон хэзээ хамгийн сүүлд ашигласан байдлаар нь авч үзвэл Ажил олгогчдын 43.0% нь 2023 онд бүртгүүлсэн бөгөөд цөөн тооны (18.4%) ажил олгогч 2025 онд шинээр нэгдсэн байна. Харин ажил хайгчдын хувьд 2024 онд бүртгүүлсэн хувь хамгийн өндөр (55.0%) байгаа нь тухайн жилд идэвхтэй ажил хайлт явагдсан байж болзошгүйг харуулж байна.

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан ажил олгогч, ажил хайгч нарын ерөнхий шинж чанар /хувь/

	Ерөнхий шинж чанар	Ажил олгогч	Ажил хайгч
Бүртгүүлсэн он	2023	43.0	34.9
	2024	38.6	55.0
	2025	18.4	10.1
Бүртгүүлсэн төхөөрөмж	Гар утас	16.7	74.2
	Компьютер, таблет	81.6	24.9
	Дээрх бүгд	1.8	1.0
Хамгийн сүүлд хэзээ ашигласан	1-7 хоногийн өмнө	5.3	0.5
	8-14 хоногийн өмнө	0.9	1.4
	15-30 хоногийн өмнө	8.8	1.9
	Сарын өмнө	10.5	9.1
	Хэдэн сарын өмнө	30.7	14.4
	Жилийн өмнө	14.9	71.3
	Бүртгүүлснээс хойш ашиглаагүй	29.0	1.4
	Ажилд орсноос хойш ашиглаагүй	0.0	0.5
Total		100%	100%

Ажил хайгчдын 74.2% нь гар утсаар бүртгүүлсэн бол, ажил олгогчдын 81.6% нь компьютер, таблет ашигласан байна. Ажил хайгчдын 71.3% нь жилийн өмнө хамгийн сүүлд системийг ашигласан бол зөвхөн 0.5% нь сүүлийн 1 долоо хоногийн дотор ашигласан байна. Харин ажил олгогчдын 30.7% нь хэдэн сарын өмнө ашигласан, 29.0% нь бүртгүүлсэн ч огт ашиглаагүй байна.

4.2 “И-жоб” платформын сэтгэл ханамж


Ажил олгогч нарын хувьд ажилтан хайх, авах, ажил хайгчийн хувьд ажил хайх /ажилгүй иргэн ажлын байр хайх/ зорилгоор платформд бүртгүүлсэн нь хамгийн өндөр буюу 67.1%-ийг эзэлж байна. Харин Ажилгүйдлийн тэтгэмж авах зорилгоор бүртгүүлсэн хүмүүс 15.8% байгаа нь хоёр дахь өндөр үзүүлэлт байна.

Зураг 29. Ямар зорилгоор бүртгүүлсэн /хувь/




Иргэдийн олонх нь ажил хайх зорилгоор бүртгүүлж байгаа нь хөдөлмөрийн зах зээл дээр иргэдэд ажлын байрны эрэлт өндөр байгааг илтгэж байна. Харин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр болон мэдээлэл авах зорилгоор бүртгүүлсэн хүмүүсийн тоо маш бага байгаа нь эдгээр чиглэлийн талаарх мэдээлэл, сурталчилгааг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Зураг 30. Платформыг хэрэглэхэд хялбар байдал /хувь/



Судалгааны үр дүнгээс харахад ажил хайгчид болон ажил олгогчид аль аль нь платформыг ашиглахад хялбар гэж үнэлсэн байна. Ажил хайгчдын олонх буюу 53.6% нь, харин ажил олгогчдын 40.4% нь “Хялбар” гэж үзжээ. Мөн ажил хайгчдын 33.5%, ажил олгогчдын 36.0% нь “Дунд зэрэг” гэж үнэлсэн нь ижил төстэй байна. Харин ажил олгогчдын 14.9% нь “Төвөгтэй” гэж хариулсан үр дүн ажил хайгчдын 6.2%-аас өндөр байгаа нь ялгаатай тал юм. Нөгөө талаар, маш хялбар гэж үзсэн хувь хоёр талд хоёуланд нь 2–3% орчим байгаа нь платформд илүү оновчтой, хэрэглэгчдэд ээлтэй байдлыг сайжруулах боломж байгааг харуулж байна. Ерөнхийдөө ажил хайгчид платформыг ажил олгогчдоос илүү хялбар гэж дүгнэсэн нь тухайн хэрэглэгчдэд ойлгомжтой байгааг харуулж байна.

Зураг 31. Платформын өнгө, дүрслэл, дизайн /хувь/




Платформын өнгө, дүрслэл, дизайн-ыг ажил олгогч болон ажил хайгчийн үнэлгээгээр авч үзвэл, ихэнх оролцогчид эергээр дүгнэсэн. Ажил олгогчдын 44.7%, ажил хайгчдын 51.2% нь “Тохиромжтой” гэж үзсэн бол, “Дунд зэрэг” гэж хариулсан хувь нь ажил олгогчдын дунд 28.1%, ажил хайгчдын дунд 33.0% ийг бүрдүүлж байв. Харин “Тохиромжгүй” болон “Огт тохиромжгүй” гэж үзсэн хувь харьцангуй бага буюу ажил олгогчдын 11.5%, ажил хайгчдын 6.7% нь байна. “Маш тохиромжтой” гэж үзсэн хүмүүсийн хувь бага байгаа нь (ажил олгогч 5.3%, ажил хайгч 1.9%) платформын өнгө, дүрслэл, дизайныг илүү сайжруулах боломжтойг харуулж байна. Ерөнхийдөө ажил хайгчид ажил олгогчдоос арай илүү эергээр үнэлсэн нь харагдаж байна.

Зураг 32. Платформын талаарх мэдээллийг хэнээс авсан бэ? /хувь/



Платформын талаарх мэдээллийг хэнээс авсан байдлыг авч үзвэл, ажил олгогчид ихэвчлэн аймаг, дүүргийн мэргэжилтнээс 51.8% мэдээлэл авсан бол ажил хайгчид илүүтэйгээр зурагт, радио, интернэт зэрэг бие даасан эх сурвалжаас 42.6% мэдээлэл авчээ. Аймаг, дүүргийн мэргэжилтнээс мэдээлэл авсан ажил хайгчид 28.7% байгаа нь ажил олгогчдоос харьцангуй бага байна. Харин сум, хорооны мэргэжилтнээс мэдээлэл авсан ажил хайгчдын хувь 12.9% ажил олгогчдоос 3.5% өндөр байгаа нь ялгаатай тал юм. Сонин, зарын сайтаас мэдээлэл авсан хувь хоёр талд ижил түвшинд (1.8–1.9%) байна.


Зураг 33. Платформд бүртгүүлэх алхам хэр ойлгомжтой байсан бэ? /хувь/



Судалгаанд оролцсон ажил олгогчид болон ажил хайгчдын дийлэнх нь бүртгэлийн алхмыг ойлгомжтой гэж үнэлсэн. Тодруулбал, ажил олгогчдын 57.9%, ажил хайгчдын 56.0% нь “Ойлгомжтой” гэж, ажил олгогчдын 22.8%, ажил хайгчдын 31.1% нь “Дунд зэрэг” гэж тус тус хариулсан байна.

“Маш ойлгомжтой” гэсэн сонголтыг ажил олгогчдын 4.4%, ажил хайгчдын 2.9% өгсөн нь харьцангуй бага үзүүлэлттэй байна. Бүртгэлийн алхмуудын ерөнхий ойлгомжтой байдал өндөр хувьтай гарсан нь платформын хэрэглэгчийн интерфэйс болон зааварчилгаа үндсэндээ оновчтой байгааг харуулж байна.

Зураг 34. Ажлын зар хангалттай, олон төрөл байсан эсэх /хувь/



“И-жоб” платформд байршсан ажлын байр, ажил хайгчийн мэдээлэл хангалттай байсан эсэх талаар “Ажил олгогч” болон “Ажил хайгч” нараас тодруулахад ажил олгогч нарын 46.5%, ажил хайгч нарын 43.1% нь “Үгүй” гэсэн хариултыг сонгосон байна. Үүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байж болно. Тухайлбал ажлын байрны зар хангалттай тавигдахгүй ажил хайгч болон ажил олгогч нар “И-жоб” платформд бүртгэл бага хийлгэдэг байж болно. Мөн ажлын байрны нэршил, эдийн засгийн салбарын төрөл хангалтгүй байгаа нь мөн нөлөөлдөг байж болох юм.


Зураг 35. Ажилд зуучлал цахим хэлбэрт шилжсэний давуу тал /хувь/



Ажил олгогч болон ажил хайгч нарын хамгийн их үнэлсэн давуу тал “Цаг хугацаа хэмнэсэн” нь хоёр талд хамгийн чухал давуу тал байв. Энэ нь цахим хэлбэрийн гол давуу тал нь ажил хайх болон ажилд хүн хайх хугацааг мэдэгдэхүйц багасгадаг гэдгийг харуулж байна. Ажил хайгч, ажил олгогчдоос мөн орон зайнаас үл хамаарах боломжийг онцолжээ.

Үүнээс харахад ажилд зуучлал цахим хэлбэрт шилжсэнээр ажил хайгч болон ажил олгогч аль алинд нь цаг хугацаа болон орон зайны хязгаарлалтыг арилгах, зардлыг бууруулах зэрэг томоохон давуу талууд бий болжээ. Гэсэн хэдий ч, зарим тохиолдолд хэрэглэгчдийн цахим хэрэглээний туршлагагүй байдал нь сул тал болж байна.

Зураг 36. Ажил хайгч болон ажлын байрны мэдээлэл таны шаардлагад хэр нийцдэг эсэх /хувь/



Судалгаанд оролцогчдын дунд “Дунд зэрэг нийцдэг” гэсэн хариулт хамгийн өндөр хувийг бүрдүүлж байсан бол “Сайн нийцдэг” гэж үзсэн ажил олгогчдын хувьд 24.6%, ажил хайгчдын 31.6% байна. Харин “Муу” гэж үнэлсэн ажил олгогчдын 30.7%, ажил хайгчдынх 14.4% -ийг бүрдүүлж байгаа нь ажил олгогчдын дунд сөрөг үнэлгээ харьцангуй өндөр байгааг харуулж байна.

Ажил олгогчдод платформыг ашиглахад ажил хайгчдаас илүүтэйгээр хүндрэл тулгардаг байна. Харин ажил хайгчдын ихэнх нь хүндрэлгүй гэж хариулсан. Хоёр талд тодорхой хэмжээний хэсэг нь хариулт өгөөгүй.

Зураг 37. Үүссэн хүндрэл бэрхшээл /хувь/



“И-жоб” платформыг ашиглах үед хүндрэл бэрхшээл үүсдэг эсэх талаар тодруулахад ажил олгогчдод платформыг ашиглахад ажил хайгчдаас илүүтэйгээр хүндрэл тулгардаг байна. Харин ажил хайгчдын ихэнх нь хүндрэлгүй гэж хариулсан байна. Энэхүү асуудлаар судалгааны үр дүнгээс харахад ажил хайгчдын хувьд “Нууц үгийн мэдээлэл ирэхгүй удах” болон “Бусад” төрлийн бэрхшээлүүд хамгийн их тохиолдсон бол, ажил олгогчдын хувьд мөн адил “Нууц үгийн мэдээлэл ирэхгүй удах” асуудлаас гадна системийн алхам, дараалал нь ойлгомжгүй байдал өндөр хувьтай байгаа нь ажиглагдаж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд системийн найдвартай ажиллагаа болон хэрэглэгчийн ашиглалт болон туршлагыг нэмэгдүүлэх, сайжруулах шаардлагатай байна.

Зураг 38. Платформын юуг сайжруулах шаардлагатай вэ? /хувь/



Оролцогчдын хувьд платформыг сайжруулах хамгийн их шаардлага нь “Ажлын байрны төрөл, тоог нэмэгдүүлэх” асуудал байна. Ажил олгогчдын 33.5% нь, ажил хайгчдын нь 45.7% нь тухайн асуудлыг онцолсон. Энэ нь зах зээл дээрх ажлын байрны боломж, төрөл, тоо хангалтгүй байгааг харуулж байна. “Системийн ажиллагааг илүү хялбаршуулах, амар болгох” шаардлагыг ажил олгогчдын 12.6% нь, ажил хайгчдын 6.4% нь, “Хайлтын болон шүүлтүүрийн системийг сайжруулах” шаардлагыг ажил олгогчдын 3.6%, ажил хайгчдын 9.3% нь дурдсан байна. Энэ нь хэрэглэгчийн туршлагыг нэмэгдүүлэх, мэдээлэл хайх үйл явцыг оновчтой болгох шаардлагатайг харуулж байна.

Дээрх үр дүнгүүдээс хэрэглэгчдийн хамгийн их шаардлага нь ажлын байрны тоо болон төрөл нэмэгдүүлэх асуудал байсан. Үүнээс гадна системийн ажиллагаа, хайлт, шүүлтүүрийн оновчлол, мэдээллийн шинэчлэл, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хэрэгцээ өндөр байна. Ажил хайгчид талаас үйлчилгээний илүү ойлгомжтой байдал, мэдээллийн ил тод байдлыг онцгой анхаарах хэрэгтэйг дурдсан.

Ажил олгогч болон ажил хайгчийн сэтгэл ханамж

Гурван бүлэг хэрэглэгчдийн “И-жоб” платформын хэрэглэгчийн сэтгэл ханамжийг ажил хайгч болон ажил олгогчийн хувьд бусдад санал болгох гэдэг хувьсагчаар үнэлэх ба энэ нь хэрэглэгчдийн нас, хүйс, боловсрол, УБ хотод оршин суудаг эсэх, ажил олгогч, мэргэжилтэн эсэх гэсэн хувьсагчтай хамааралтай эсэхийг хэрэглэгчийн бүлэг тус бүрээр т-тестээр үнэлсэн.

Хүснэгт 5. Бусдад санал болгох уу?

Хувьсагчид	Бусдад санал болгоно		Р утга
	Тийм	Үгүй	
Ажил хайгч			
Эмэгтэй	0.741	0.573	0.011
Дээд боловсролтой	0.708	0.597	0.116
35 хүртэлх насны	0.690	0.638	0.441
Улаанбаатарт амьдардаг	0.670	0.670	0.999
5 хүртэл жил ажилласан	0.680	0.660	0.763
Утас ашигладаг	0.658	0.703	0.535
Өнгөрсөн сард хэрэглэсэн	0.875	0.661	0.137
Ажил олгогч			
Эмэгтэй	0.625	0.653	0.791
Дээд боловсролтой	0.638	0.555	0.660
35 хүртэлх насны	0.487	0.712	0.021
Улаанбаатарт амьдардаг	0.636	0.621	0.880
5 хүртэл жил үйл ажиллагаа явуулсан	0.555	0.700	0.114
Утас ашигладаг	0.736	0.610	0.283
Өнгөрсөн сард хэрэглэсэн	0.482	0.682	0.069

Тайлбар: “И-Жоб” судалгааны өгөгдлөөс тооцоолов.

Эмэгтэй, дээд боловсролтой бөгөөд саяхан “И-жоб” платформ хэрэглэсэн ажил хайгчид “И-жоб” платформыг бусдад санал болгох магадлалтай бол боловсрол, байршил, ажлын туршлага, утсаар ашигладаг эсэх нь огт хамааралгүй байна. Харин ажил олгогчдын хувьд 35 хүртэл насны, саяхан хэрэглэсэн хэрэглэгчид бусдад санал болгох магадлал илүү өндөр байна.

БҮЛЭГ 5. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

5.1 Дүгнэлт

РЕГРЕССИЙН ШИНЖИЛГЭЭ

Бид тэгшитгэл (1)-ын пробит загварыг үнэлснээр “И-жоб” платформ хэрэглэгчдийн сэтгэл ханамжтай байх магадлал ба бусад тайлбарлагч хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээг хийх боломжтой.

$$\text{logit}(P(Y = 1)) = \ln\left(\frac{P(Y = 1)}{1 - P(Y = 1)}\right) = \beta_0 + \beta_1 X_1 + \beta_2 X_2 + \dots + \beta_k X_k \quad (1)$$

$P(Y = 1)$ нь “И-жоб” платформд сэтгэл ханамжтай байх магадлал,

$\beta_0, \beta_1, \beta_2, \dots, \beta_k$ нь тайлбарлагч хувьсагчдын өмнөх коэффициентууд.

$X_1, X_2, \dots, X_k$ нь тайлбарлагч хувьсагчид бөгөөд шинжилгээнд ашиглах тайлбарлагч хувьсагчид болон тэдгээрийн статистик үзүүлэлтүүдийг Хүснэгт 6-д харуулсан.

Хүснэгт 6. Сэтгэл ханамж

Тайлбарлагч хувьсагчид	Ажил хайгч	Ажил олгогч	Мэргэжилтэн
Тогтмол	-0.039	0.384	-0.711
Эмэгтэй	0.431**	-0.046	0.012
Дээд боловсролтой	0.228	0.296	0.340
35 хүртэлх насны	0.278	-0.602**	-0.058
Улаанбаатарт амьдардаг	-0.031	0.200	0.415*
5 хүртэл жил ажилласан	-0.080	0.703	0.135
5 хүртэл жил үйл ажиллагаа эрхэлсэн			-0.262
Утас ашигладаг	-0.057	0.342	
Өнгөрсөн сард хэрэглэсэн	0.490	-0.442	
Сар тутам хэрэглэдэг			0.215
Газар/хэлтсийн дарга			-0.579*
AIC	270.47	154.18	219.51
Ажиглалтын тоо	208	106	154

Эмэгтэй ажил хайгчдын сэтгэл ханамж эрэгтэйчүүдээс илүү өндөр байна. Ажил олгогчдын сэтгэл ханамж нь наснаас эерэг хамааралтай. Харин мэргэжилтнүүдийн хувьд Улаанбаатар амьдардаг мэргэжилтнүүд сэтгэл ханамж өндөртэй байдаг бол газар, хэлтсийн удирдлагын хувьд сэтгэл ханамж нь мэргэжилтнүүдээс бага байна.

Ажил хайгч, ажил олгогч болон мэргэжилтнүүд бүгд “И-жоб” платформын бүтэц үйл ажиллагаанд ерөнхий үнэлгээ өгсөн. Ерөнхий үнэлгээг хамааран хувьсагч болгож нийт түүвэр дээр үнэлэхэд ажил хайгч болон ажил олгогчийн өмнөх коэффициент мэргэжилтнүүдийнхээс өндөр бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой байв.

Ажил хайгч болон ажил олгогч нар “И-жоб” платформд мэргэжилтнүүдээс илүү сэтгэл ханамжтай байна. Сэтгэл ханамж болон ихэнх хувьсагчдын хамаарал статистикийн хувьд ач холбогдолтой биш байна. Гурван бүлэг хэрэглэгчдийн түүврийн хэмжээ бага байгаа нь үүнд нөлөөлсөн байж болох юм.

5.2 Зөвлөмж

1. Мэдээллийн чанар, стандарт, болон хүртээмжийг сайжруулах:

- Мэдээллийн чанарыг сайжруулах: “И-жоб” платформ дээрх мэдээллийг шинэчлэх, баталгаажуулах, тодорхой нэг стандартын дагуу оруулах хэрэгтэй. Давхардалгүй, зөв мэдээлэл байршуулж, системийн мэдээллийн алдааг багасгах шаардлагатай.
- Мэдээллийн хуваарилалт, хүртээмжийг сайжруулах: Үр дүнтэй мэдээллийн хуваарилалтыг хэрэгжүүлж, системийн мэдээ хүлээн авах боломжийг хэрэглэгчдэд илүү хялбар болгож, шаардлагатай бүх мэдээллийг нэг платформд нийлүүлж өгөх нь чухал. Мөн хэрэглэгчдэд системийн мэдээлэл хэзээ шинэчлэгдэж байгаа талаар тодорхой мэдээлэл өгөх хэрэгтэй.

2. Системийн автоматжуулалт болон ажиллагааг хялбаршуулах:

- Автоматжуулалтыг нэмэгдүүлэх: “И-жоб” платформ дээрх ажлын процессыг автоматжуулах нь мэдээллийн алдааг багасгах, хэрэглэгчийн оруулж буй мэдээллийг хянах, процессыг хурдасгах боломжийг олгоно.
- Хэрэглэгчийн интерфэйсийг сайжруулах: Хэрэглэгчдийн туршлага илүү эерэг байх боломжтой. Тодорхой нэгэн үйлдэл, зааварчилгаа, мэдээлэл хүргэхэд илүү хялбар, ойлгомжтой интерфэйс, товчлууруудыг ашиглах хэрэгтэй.

3. Ажлын байрны мэдээллийн хүртээмжийг сайжруулах:

- Ажлын байрны зарын тоог нэмэгдүүлэх: Платформд бүртгүүлэхээс гадна, ажлын байрны мэдээллийг нэмэгдүүлэх, олон төрлийн салбарт зар байршуулсан байх хэрэгтэй.

Тиймээс, ажил олгогчид платформыг идэвхтэй ашиглахад урам зориг өгч, тэдний оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.

- Ажлын байрны мэдээллийг байнга шинэчлэх: Ажил хайгчдын хувьд хамгийн чухал зүйл бол ажлын байрны шинэ мэдээлэл. Ажил олгогчдын мэдээллийг илүү түргэн, шуурхай шинэчлэх хэрэгтэй.

4. Мэдээллийн аюулгүй байдал, техникийн асуудлуудыг шийдвэрлэх:

- Системийн найдвартай ажиллагаа: Системийн доголдол, нууц үг сэргээх асуудлуудыг хурдан шийдвэрлэх хэрэгтэй. Платформын ажиллагааг сайжруулж, техникийн бэрхшээлүүдийг хамгийн богино хугацаанд шийдэх нөхцөлүүдийг бүрдүүлэх хэрэгтэй.
- Мэдээллийн аюулгүй байдал: Иргэдийн хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд платформ дээрх мэдээллийг шифрлэх, хакерын халдлагаас хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай

5. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулах:

- Танин мэдэхүйн боловсролыг нэмэгдүүлэх: Платформын ашиглалт, бүртгэл, системийн үйл ажиллагааг ойлгоход хэрэглэгчдэд зориулсан видео, гарын авлага, зааварчилгаа нэмэх. Ингэснээр бүртгэл болон бусад үйл явцын хэрэглэгчийн түвшинд ойлгомжтой, хялбар болно.
- Идэвхтэй хэрэглэгчдийн санал хүсэлтийг сонсох: Системийн талаар хэрэглэгчдийн санал хүсэлт авах, системийг хэрхэн сайжруулах талаар тогтмол судалгаа явуулах.

6. Судалгаа, дүн шинжилгээ хийх боломжийг өргөжүүлэх:

- Тайлан мэдээ гаргах, дүн шинжилгээ хийх боломжийг хөнгөвчлөх: Мэргэжилтнүүдийн тайлан, дүн шинжилгээ хийх эрхийг нэмэгдүүлэх, тайлан гаргах үйл явцыг хөнгөвчлөх хэрэгтэй. Ингэснээр байгууллага нь мэдээллийг зөвөөр боловсруулах, шийдвэр гаргах процессоо хурдасгах боломжтой болно.

7. Хэрэглэгчийн интерфэйсийг илүү тохиромжтой болгох:

- Ажил олгогч, ажил хайгчдын хэрэглэгчийн интерфэйсийг оновчтой болгох: Ажил олгогчдын хувьд зааварчилгааны хэсгийг энгийн, ойлгомжтой болгох шаардлагатай. Үүний тулд платформын хөтөч болон зааварчилгааны хэсэгт засвар оруулах шаардлагатай.

8. Иргэдийн цахим чадварыг дэмжих:

- Цахим боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх: Платформ ашиглахад хүндрэлтэй иргэдийн цахим чадварыг сайжруулах, сургалт зохион байгуулах нь хэрэглэгчийн оролцоог нэмэгдүүлэх чухал алхам байх болно.

Техникийн шинэчлэл, автоматжуулалт болон ашиглахад хялбар интерфейс нь хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, платформын үр ашгийг дээшлүүлэх үндсэн түлхүүр болох болно.

ХАВСРАЛТ

Хавсралт хүснэгт 1. Газар/хэлтсийн дарга хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хялбар, оновчтой, шуурхай шийдвэрлэж буй байдал /хувь/

Газар/хэлтсийн дарга	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх	17.9	64.3	14.3	3.6	
Хувийн хөдөлмөрийн биржтэй мэдээлэл солилцох	14.3	17.9	42.9	17.9	7.1
Ажил зуучлалын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх	10.7	53.6	25.0	10.7	
Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх	3.6	3.6	57.1	25.0	10.7
Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	14.3	42.9	32.1	10.7	
Статистик, тоон үзүүлэлт, тайланг ашиглах, хэрэглэх	3.6	21.4	42.9	21.4	10.7
Мэргэжлийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох	3.6	28.6	46.4	21.4	0.0
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн үйлчилгээг цахимжуулах	32.1	50.0	7.1	10.7	0.0

Хавсралт хүснэгт 2. Мэргэжилтэн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хялбар, оновчтой, шуурхай шийдвэрлэж буй байдал /хувь/

Мэргэжилтэн	Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн
Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх	8.2	15.7	46.3	23.1	6.7
Хувийн хөдөлмөрийн биржтэй мэдээлэл солилцох	11.9	28.4	34.3	22.4	3.0
Ажил зуучлалын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх	6.0	23.1	32.8	29.1	9.0
Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх	6.7	14.9	41.8	32.1	4.5
Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	6.7	20.1	32.8	32.1	8.2
Статистик, тоон үзүүлэлт, тайланг ашиглах, хэрэглэх	8.2	15.7	46.3	22.4	7.5
Мэргэжлийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох	7.5	24.6	44.8	18.7	4.5
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн үйлчилгээг цахимжуулах	6.0	23.1	32.8	30.6	7.5

Хавсралт хүснэгт 3. Газар/хэлтсийн дарга “И-жоб” платформын бүтэц, ажиллагаа, ашиглалт /хувь/

Газар/хэлтсийн дарга	Бүрэн санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд	Санал нийлнэ	Бүрэн санал нийлнэ
Ашиглахад маш хялбар, ойлгомжтой үйлдлийн дараалалтай	7.1	17.9	35.7	28.6	10.7
Хэрэглэгчийн тохиргоо энгийн, тусламж дэмжлэг сайтай	17.9	64.3	17.9	0.0	0.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглахад тохиромжтой	10.7	39.3	42.9	7.1	0.0
Мэдээлэл хоорондын уялдаа, холбоо маш сайн	3.6	28.6	57.1	10.7	0.0
Техник хэрэгсэл, тусгай орчин нөхцөлийн шаардлага бага	7.1	21.4	50.0	21.4	0.0
Ажлын ачаалал эрс багассан	3.6	35.7	35.7	21.4	3.6
Бүх түвшний хэрэглэгчийн механик ажиллагааг хөнгөвчилсөн	10.7	17.9	57.1	14.3	0.0
Хэрэглэгчийн эрхийн зохицуулалт нь ажлын шаардлагад бүрэн нийцдэг	14.3	25.0	46.4	14.3	0.0
Ажил зуучлалын үйл явцыг бүрэн хянаж чаддаг болсон	35.7	50.0	14.3	0.0	0.0
Хэрэглэгчийн мэдээллийг давхардалгүй, бүрэн удирддаг	10.7	28.6	35.7	17.9	7.1
Профайлинг үнэлгээ цахимжсан нь маш тохиромжтой	10.7	25.0	39.3	21.4	3.6
Хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой	10.7	21.4	42.9	25.0	0.0
Тайлан, мэдээг шуурхай, олон хэлбэрээр гаргадаг болсон	10.7	14.3	50.0	21.4	3.6
Бүх төрлийн мэдээ, тайланд олон төрлийн дүн шинжилгээ хийх боломжтой	10.7	14.3	46.4	25.0	3.6

Хавсралт хүснэгт 4. Мэргэжилтэн “И-жоб” платформын бүтэц, ажиллагаа, ашиглалт /хувь/

Мэргэжилтэн	Бүрэн санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд	Санал нийлнэ	Бүрэн санал нийлнэ
Ашиглахад маш хялбар, ойлгомжтой үйлдлийн дараалалтай	9.7	17.9	31.3	28.4	12.7
Хэрэглэгчийн тохиргоо энгийн, тусламж дэмжлэг сайтай	6.7	17.9	37.3	28.4	9.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглахад тохиромжтой	15.7	25.4	39.6	15.7	3.7
Мэдээлэл хоорондын уялдаа, холбоо маш сайн	6.0	28.4	34.3	24.6	6.7
Техник хэрэгсэл, тусгай орчин нөхцөлийн шаардлага бага	5.2	20.1	44.8	20.9	9.0
Ажлын ачаалал эрс багассан	11.9	24.6	36.6	18.7	8.2
Бүх түвшний хэрэглэгчийн механик ажиллагааг хөнгөвчилсөн	8.2	19.4	46.3	19.4	6.7
Хэрэглэгчийн эрхийн зохицуулалт нь ажлын шаардлагад бүрэн нийцдэг	7.5	15.7	41.8	26.1	9.0
Ажил зуучлалын үйл явцыг бүрэн хянаж чаддаг болсон	8.2	23.1	33.6	24.6	10.4
Хэрэглэгчийн мэдээллийг давхардалгүй, бүрэн удирддаг	9.0	21.6	28.4	29.9	11.2
Профайлинг үнэлгээ цахимжсан нь маш тохиромжтой	11.2	15.7	31.3	29.1	12.7
Хөтөлбөр, арга хэмжээний мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой	8.2	16.4	36.6	29.9	9.0
Тайлан, мэдээг шуурхай, олон хэлбэрээр гаргадаг болсон	8.2	15.7	40.3	26.1	9.7
Бүх төрлийн мэдээ, тайланд олон төрлийн дүн шинжилгээ хийх боломжтой	7.5	16.4	44.8	21.6	9.7

Хавсралт хүснэгт 5. Газар/хэлтсийн дарга “И-жоб” платформыг ашиглах үед тулгардаг хүндрэл, асуудал /хувь/

Газар/хэлтсийн дарга	Маш хүндрэлтэй	Хүнд рэлтэй	Дунд	Хүнд рэлгүй	Маш хүндрэлгүй
Систем гацах, ажиллахгүй байх	3.6	10.7	21.4	32.1	32.1
Оруулсан мэдээлэл алга болох, устах, харагдахгүй байх	7.1	14.3	28.6	35.7	14.3
Мэдээллийн эргэх холбоогүй	3.6	17.9	32.1	28.6	17.9
Тусламж, үйлчилгээ авахад хүндрэлтэй байх	14.3	42.9	28.6	14.3	0.0
Үйл явцыг хянах боломжгүй	3.6	10.7	39.3	35.7	10.7
Зар, мэдээлэл шинэчлэгдэхгүй байх	10.7	7.1	32.1	32.1	17.9
Системд хандах эрх сэргээхэд хүндрэлтэй байх	10.7	14.3	32.1	21.4	21.4
Систем дэх мэдээллийг давтан шивэх	3.6	7.1	53.6	21.4	14.3

Хавсралт хүснэгт 6. Мэргэжилтэн “И-жоб” платформыг ашиглах үед тулгардаг хүндрэл, асуудал /хувь/

Мэргэжилтэн	Маш хүндрэлтэй	Хүнд рэлтэй	Дунд	Хүнд рэлгүй	Маш хүндрэлгүй
Систем гацах, ажиллахгүй байх	4.5	13.4	18.7	39.6	23.9
Оруулсан мэдээлэл алга болох, устах, харагдахгүй байх	5.2	20.9	18.7	34.3	20.9
Мэдээллийн эргэх холбоогүй	3.0	14.9	28.4	38.1	15.7
Тусламж, үйлчилгээ авахад хүндрэлтэй байх	0.7	21.6	29.9	32.8	14.9
Үйл явцыг хянах боломжгүй	2.2	23.9	23.9	38.8	11.2
Зар, мэдээлэл шинэчлэгдэхгүй байх	2.2	17.9	37.3	32.8	9.7
Системд хандах эрх сэргээхэд хүндрэлтэй байх	4.5	24.6	32.8	29.1	9.0
Систем дэх мэдээллийг давтан шивэх	2.2	21.6	33.6	27.6	14.9

Хавсралт хүснэгт 7. Газар/хэлтсийн дарга “И-жоб” платформд сайжруулах шаардлагатай зүйлс /хувь/

Газар/хэлтсийн дарга	Бүрэн санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд	Санал нийлнэ	Бүрэн санал нийлнэ
Мэдээллийн уялдаа, холбоог сайжруулах	3.6	10.7	10.7	39.3	35.7
Мэдээллийн тоо, төрөл, чанарыг сайжруулах	7.1	7.1	42.9	42.9	0.0
Иргэдийн мэдээллийн технологийн ур чадварт нийцүүлэх	7.1	7.1	14.3	42.9	28.6
Системийн ажиллагааг илүү хялбаршуулах	7.1	10.7	10.7	28.6	42.9
Бүртгэл, анкет үүсгэх маягыг өөрчлөх	7.1	10.7	21.4	39.3	21.4
Хайлтын болон шүүлтүүрийн системийг хялбар болгох	10.7	10.7	28.6	25.0	25.0
Дизайн, харагдах байдлыг ойлгомжтой болгох	7.1	10.7	28.6	32.1	21.4
Тайлан мэдээ гаргах, мэдээлэл татах үйл ажиллагааг сайжруулах	7.1	3.6	25.0	28.6	35.7
Ажил хайгчийн бүртгэлийн давхардал үүсгэдэггүй болгох	14.3	10.7	25.0	17.9	32.1

Хавсралт хүснэгт 8. Мэргэжилтэн” И-жоб” платформд сайжруулах шаардлагатай зүйлс /хувь/

Мэргэжилтэн	Бүрэн санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд	Санал нийлнэ	Бүрэн санал нийлнэ
Мэдээллийн уялдаа, холбоог сайжруулах	5.2	10.4	23.9	22.4	38.1
Мэдээллийн тоо, төрөл, чанарыг сайжруулах	6.0	9.7	20.9	28.4	35.1
Иргэдийн мэдээллийн технологийн ур чадварт нийцүүлэх	6.0	9.0	18.7	31.3	35.1
Системийн ажиллагааг илүү хялбаршуулах	6.0	9.0	18.7	23.9	42.5
Бүртгэл, анкет үүсгэх маягыг өөрчлөх	8.2	15.7	21.6	20.1	34.3
Хайлтын болон шүүлтүүрийн системийг хялбар болгох	6.7	11.2	22.4	21.6	38.1
Дизайн, харагдах байдлыг ойлгомжтой болгох	7.5	15.7	25.4	24.6	26.9
Тайлан мэдээ гаргах, мэдээлэл татах үйл ажиллагааг сайжруулах	5.2	9.7	17.2	30.6	37.3
Ажил хайгчийн бүртгэлийн давхардал үүсгэдэггүй болгох	10.4	10.4	25.4	20.9	32.8

